

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дүгээр сарын 19-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-10

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 11-39

1. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 11-39

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
05 дугаар сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Жавхлан, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг, Д.Өнөрболор.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга С.Цэрэндулам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батболд, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бямбадагва, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга О.Цолмон, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Барилга хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн дарга Г.Нямцэцэг, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Ариунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан

хэлтсийн референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Ажлын хэсгийн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Батлут, Х.Ганхуяг, Т.Энхтүвшин, Н.Ганибал, М.Оюунчимэг, Ж.Чинбүрэн, С.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга С.Цэрэндулам, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуван, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Нэгдсэн хуралдаан хуралдах болсон тул хуралдаан 10 цаг 12 минутаас 11 цаг 47 минутад түр завсарлав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4-т заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2, 3, 4 дүгээр заалтыг 2 дугаар заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	7
Бүгд:	14

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2, 3, 4 дүгээр заалтыг 2 дугаар заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөл доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “төлөвлөж

хэрэгжүүлэх,” гэсний дараа “нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах,” гэж нэмж, мөн зүйлийн “мөнгөний бодлогын тохируулгыг оновчтой хийх,” гэснийг “мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 12
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.” гэсэн агуулгатай 2.3 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 12
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Тадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 12
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.1.1 дэх заалтын “Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын судалгааны ажлыг гүйцэтгэх” гэснийг “Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх” гэж, мөн шалгуур үзүүлэлтийн “Талбай хамралтад” гэснийг “Нислэгт хамрагдсан талбай” гэж, үр дүнгийн үзүүлэлтийн суурь түвшин “66” гэснийг “0” гэж, хүрэх түвшин “100” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.1 дэх заалтын “Зэсийн” гэснийг “Зэс, алт, мөнгөний” гэж өөрчилж, мөн заалтад Төсөл, арга хэмжээнд “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Зорилтот түвшинд “100” гэж, Хариуцагч байгууллагад “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” гэсэн 2.2.2.2 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.4 дэх дэд заалтын Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээний “парк” гэснийг “паркийн дэд бүтцийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.9 дэх дэд заалтын Зорилтот түвшний “80” гэснийг “60” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар асуултын 2.3.2.5 дахь дэд заалтын Зорилтот түвшний “50” гэснийг “100” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн төсөл” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “20” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “2,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд Үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн Шинжлэх ухаан, технологийн /суурь, хэрэглээний технологи/ судалгаа, хөгжүүлэлтийн ажил” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “350” гэж, Зорилтот түвшинд “450” гэж, Санхүүжилтэд “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1.7 дахь дэд заалтын Санхүүжилтэд “62,493.82” гэснийг “19,388.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1.2 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтын Шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь онд “2022” гэж, Суурь түвшинд “0.13” гэж, Зорилтот түвшинд “0.2” гэж, Мэдээллийн эх сурвалжийг “ҮСХ” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүйд “Статистикийн мэдээ” гэж, Мэдээлэл цуглуулах давтамжид “Жилд нэг удаа” гэж, Хариуцах байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Бодлогын үндэслэл” хэсгийн Алсын хараа /АХ/, 2.3.2.16 дахь дэд заалтын “3.2.14” гэснийг “6.4.22” гэж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /МУХТЖҮЧ/-ийн 2.1.3 дахь заалтын “4.2.2” гэснийг “4.4.3” гэж, мөн 3.1.4.1-3.1.4.5, 3.1.4.7, 3.1.4.8, 3.1.5.1 дэх дэд

заалтын “2.1.9” гэснийг “2.1.12” гэж, мөн 4.2.1.1 дэх дэд заалтын “3.6.4” гэснийг “4.2.10” гэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-ийн 6.2.3 дахь заалтын “4.3.9” гэснийг “3.5.7” гэж, мөн тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын “бүсүүд” гэснийг “бүсүүдийн” гэж, 3.2 дахь заалтын Хэмжих нэгжийн “Хүн” гэснийг “Хувь” гэж, 3.3.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлтийн “хамралт” гэснийг “хамрагдалт” гэж, 3.3.3 дахь дэд заалтын Зорилтот үр дүнгийн “нэмэгдэнэ” гэснийг “нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлтийн “насныхны” гэснийг “насны” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2 дахь заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 мвт-аар өргөтгөх” гэж, Санхүүжилтэд “16,7 тэрбум төгрөг”, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Т.Энхтүвшин нар Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.5-д “2023-2024 оны хичээлийн жилд 3 ээлжид орох нөхцөл үүссэн ерөнхий боловсролын сургуулийн шинээр баригдаж байгаа барилга байгууламжийг барина.” гэж нэмэх гэсэн саналаа татаж авав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан тайлбар хийв.

21.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 5.1.3, 5.1.4 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын 4.2.10 дахь заалт”-ыг тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.3.2.2 дахь дэд заалтын “Улсын төсөв” гэснийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, мөн хавсралтын 3.3.2.3 дахь дэд заалтын “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих” гэж, Зорилтот түвшинд “20 хувь” гэж, Санхүүжилтэд “28 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын ТЭЗҮ боловсруулах” гэж, Санхүүжилтэд “4 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэсэн 4.3.1.21 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих” гэж, Санхүүжилтэд “25 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 3.3.2 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 метр урт гүүр барих /Сүхбаатар-Баруун урт, Сүхбаатар сум/ гэж, Санхүүжилтэд “10 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтод түвшин “Ажлын гүйцэтгэл” гэж, Санхүүжих дүн “29 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133,7 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл 67,8 км” гэж, Санхүүжих дүн “43,677.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28. Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь кокс, металлургийн үйлдвэр” үйлдвэрлэл технологийн парк байгуулах” гэж, Бодлогын үндэслэлд “ЗГҮАХ-3.2.7.1” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Үр дүнгийн үзүүлэлтэд 2022 он “35”, 2024 он “35” гэж, Санхүүжих дүн “375 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Хариуцагч байгууллагад “УУХҮЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29. Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 100 км авто зам барих” гэж, Санхүүжих дүн “150,34 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл, тусламж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 09 минут үргэлжилж, 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
9 цаг 12 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ирцийг өнөөдрийн Байнгын хорооны хурлын ирцийг танилцуулъя. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн өвчтэй. Ирсэн гишүүд Өнөрболор гишүүн өвчтэй байна. Энхтүвшин, ингээд Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ, Наянтайн Ганибал гишүүн ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн байна. Чинбатын Ундрам гишүүн ирсэн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн ирсэн, Содномын Чинзориг гишүүн ирсэн, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн ирсэн. Ингээд ирц бүрдэж хурал эхэлснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хурал дахь хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл ЗГ 2023 оны 4 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудалтай өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийг танилцуулах уу, үгүй юу?

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төслийг Байнгын хорооны төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Баттөмөр даргын микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх асуудлыг 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр 10 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн дор Доржханд, Өнөрболор, Цогтгэрэл, Чинзориг нар ажигласан болно.

Ажлын хэсэг 1 удаа, дэд ажлын хэсэг 3 удаа хуралдаж тогтоолын төсөлтэй холбогдуулан 43 саналыг нь хүлээн авч судлан тогтоолын төсөл зайлшгүй тусгах шаардлагатай 16 зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн та бүгдэд тараасан. Тухайлбал тогтоолын 1 дүгээр хавсралт Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах, гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, мөн тогтоолын 2 дугаар хавсралт судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент, эдийн засгийн эргэлтэд оруулах гэсэн төсөл арга

хэмжээний хүрээнд судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээ нэвтрүүлэх төсөл, үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн шинжлэх ухаан технологийн суурь хэрэглээний технологи, судалгаа, хөгжүүлэлтийн ажил гэсэн шалгуур үзүүлэлтийг болон бусад төсөл арга хэмжээний зорилтот түвшинд хэмжих нэгж, хариуцах байгууллага зэрэгт холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан болно. Тогтоолын төслийн 3 дугаар хавсралт нь албан ёсны статистик олон статистик тоон мэдээллийн хүртээмжээс хамаарах хяналт шинжилгээний зарим үзүүлэлтийг өөрчлөхөөр тогтоол томъёолол, саналын томъёоллыг бэлтгэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн танилцуулгыг сонслоо. Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. С.Цогтгэрэл БОАЖЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга, А.Хишигбаяр ХНХ-ын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Цэдэвсүрэн БШУЯ-ны ТНБД, С.Батболд ЗТХЯ-ны ТНБД, Ч.Энх-Амгалан Соёлын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Б.Бямбадагва УУХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ТНБД, Н.Тавинбэх ЭХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны захиргаа, удирдлагын газрын дарга. Алга байна уу? Л.Лувсан ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга, зарим нь Төсвийн байнгын хороон дээр давхцаж байна уу.

Ш.Мөнхцэцэг, Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Ч.Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Балчинлуvsан Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн бодлогын газрын дарга, О.Очирваань Эдийн засаг, хөгжлийн яамны ХШУДАГ-ын дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Г.Нямцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Хөгжлийн загвар шинэчлэлийн хэлтсийн дарга, Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга, Д.Ган-Очир Монголбанкны эдийн засаг, шинжлэх ухааны доктор, О.Цолмон ХЗДХЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, аудитын газрын дарга, Э.Батболд БХБЯ-ны хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга, Т.Батцэцэг Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Ч.Гандирмаа БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Цэрэндулам БОАЖЯ-ны Бодлогын газрын дарга, С.Ариунцэцэг НЗДТГ-ын Улс, нийслэлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Д.Энхцэцэг НЗДТГ-ын замын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Ж.Сандагсүрэн НЗД-ын I дүгээр орлогч.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр нэрсийг хаая. Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүний микрофоныг нээе.

Б.Энхбаяр: Гишүүддээ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр хөгжлийн асуудал бол мэдээж хүний хөгжлөөс

үүдэлтэй. Хүнээ хөгжүүлэе гэхээр энэ боловсролын хүртээмж, чанарын асуудал бол ялангуяа Улаанбаатар хотод нэлээн тулгамдаж байгаа. Манай миний сонгогдсон БЗД гэхэд боловсролын нэг хүүхдэд ноогдох сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн байдлаараа бол нийслэл битгий хэл улсын хэмжээндээ хамгийн бага үзүүлэлттэй байгаа. 2024 онд бол БЗД нийтдээ 400 мянган хүн амтай болох гэж байна. Нийт Монгол Улсын хүн амын 10 хувь гэсэн үг, ийм том цар хүрээтэй болж байгаа юм. Сургуулийн хүртээмжийн тоог, цэцэрлэгийн хүртээмжийн тоог нэмэгдүүлэх хүрээнд хамгийн их тулгамдаж байгаа асуудал бол 1 дүгээрт газрын асуудал байгаа. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд дүүргийнхээ удирдлагууд, нийслэлийн дахин төлөвлөлтийн газартай хамтарч байгаад нийтдээ 7 байришилд улсын төсвөөс, бас нийслэл, орон нутгийн төсвөөс хөрөнгө гарч, газар чөлөөлөх ажлууд хийгдэж, 7 байришилд сургууль, цэцэрлэг барих боломжтой газар гаргачхаад байгаа. Энд нийтдээ бол 90, 91 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах тооцоо гарч ирж байна.

24 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 300 орчим тэрбум төгрөгт хөрөнгө оруулалт барих юм шиг байгаа юм багцаагаар. Ингээд аваад үзэхээр 1/3-ийг нь нэг дүүрэгт мэдээж хуваарилахгүй нь тодорхой. Энд бас сонгуулийн энэ гишүүдийн нөгөө хуваарилалт бас нөлөөлдөг юм шиг байгаа юм. Тухайлбал миний сонгогдсон 200 мянган хүн амтай БЗД-ийн 22 дугаар хороог төлөөлж Улсын Их Хуралд 2 мандат ажилладаг байхад 45 мянган хүн амтай буюу түүнээс даруй 4-5 дахин их бага хүн амтай аймаг адилхан 2 мандаттай байж байгаа юм. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь адилхан. Ингэхээр нийслэл Улаанбаатар хот тэр дундаа БЗД-ийн тухайд энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмж түүнийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх кнопны хүч сулардаг ийм нөхцөл байдал байх шиг байна. Тэгэхээр Боловсролын яам энэ дээр ирэх онд ямар бодлого

баримталж байна вэ гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь сүүлийн 5 жил үзэж байгаад манай тойрогт Дунжингаравын цаана 3км-т 640 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн комплекс цогцолбор энэ 6 сард ашиглалтад орох гэж байгаа. Сонгогчид маань ямар асуудал тавиад байна вэ гэхээр сургууль, цэцэрлэг ашиглалтад орж байдаг энд баяртай байгаа. Тэгэхдээ энд чинь нөгөө жсоохон хүүхдүүд явах гээд байгаа юм, цэцэрлэгийн хүүхдүүд, сургуулийн хүүхдүүд. Тэгээд 3км газар алхаж явна гэдэг бас их хэцүү. Эцэг, эхчүүд цаашаа хүүхдүүдээ автомашинаар тээвэрлэе гэхээр түгжрэл тэнд бол бүүм болно. Тэгэхээр нэгдсэн журмаар яг нэг хорооны тухайд бас автобус явуулах боломж дээр анхаарч байгаа зүйл байгаа юу?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ, хэд байна вэ? 2 номер дээр суучих Боловсролын яам уу хэн юм бэ? Цэдэвсүрэн дарга хэд дээр байна 5 дээр үү? 5 номер, 5 номерын микрофоныг нээ.

Л.Цэдэвсүрэн: Гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Энхбаяр гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт бид нар энэ Монгол Улсын боловсролын салбарын цэцэрлэг ЕБС-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 200 сургууль, 273 цэцэрлэг барьж ашиглалтад оруулах ийм зорилт тавиад ажиллаад ер нь энэний хэрэгжилт бол одоогийн байдлаар бол нэлээн хангалттай явж байгаа гэж үзэж байгаа. Та бүхэнд тараагдчихсан 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл дээр бол бид нар ЕБС-ийн барилга 24-ийг одоо ашиглалтад оруулна, шинээр бол ахиад 24 сургууль барина гээд ингээд тоо баримттай зүйлүүд маань тусчихсан байгаа.

Таны саяын хэлдгээр ер нь улсын хэмжээнд нийт 859 ЕБС байдгаас 296 нь нийслэлд байгаа. 296 нийслэлд байгаа сургуулиудаас бид нар өнгөрсөн жил болон энэ жил нэлээн олон судалгаа

хийгээд үзэхээр 30-35 хүүхэдтэй байх ёстой бүлэг дүүргэлт бол хэтэрчихсэн тохиолдлууд бол аягүй их байгаа. Яг БЗД-ийн хувьд ингээд яриад үзэхээр БЗД-ийн 17 сургуулийн 300 бүлэг дээр бүлэг дүүргэлт хэтэрчихсэн. Энэ нь бол юу гэсэн үг вэ гэхээр 35-аас дээш хүүхэд сурч байгаа гэсэн үг. Тийм учраас бид нар энэ 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиудыг 2 ээлж рүү шилжүүлэх ийм зорилт бас тавиад ажиглаж байгаа. Энийгээ бол хэрэгжүүлэхийн төлөө бол явна. Ер нь улсын хэмжээнд нийт 10800 гаруй бүлэг байдгаас энэний 45 хувь нь бол бүлэг дүүрэлт хэтрээд явж байгаа. Тэгээд тооцоо судалгаа хийж үзсэн. Нийслэлд бол 54 сургууль дээр энэ асуудал үүссэн. 2 долоо хоногийн өмнө бид нар нийслэлийн бүх ИТХ-д энэ асуудлуудаа танилцуулж бас шийдлүүдээ гаргасан байгаа.

Тэгээд БСШУС-ын Байнгын хорооноос өнөөдрийн энэ хурал дээр яг энэ 3 ээлжийг халахтай холбоотой асуудлуудыг бол тусгасан байгаа. Тэгэхээр энэ бол ганцхан Баянзүрх биш, нийслэлийн 6, 7 дүүрэг дээр бол энэ асуудал бол энэ төлөвлөгөөний төсөлд ороод явж байгаа.

Та сая 26 дугаар хороонд баригдаж байгаа нөгөө сургуулийг хэлж байх шиг байна. Тэгэхээр 26 дугаар сургууль юу хороонд баригдаж байгаа сургуулиа бид нар ямар ч байсан энэ 6 сард бол ашиглалтад хүлээж авна гэдгээр бол явж байгаа. Тэгээд яг таны саяын хэлдгээр автобусны асуудлыг ярьж байгаа одоо. Яагаад гэхээр яаж ч байсан гэсэн эцэг, эх хүүхдүүдээ бол тэндээс машинаар зөөх нь аягүй эрсдэлтэй. Бас яг нөгөө орчин тойрных нь барилга байгууламж нь бол хол. Тийм учраас энэ дээр бол сургуулийн яг зохион байгуулалттай автобусны асуудлыг шийдье гэсэн хувилбар яригдаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр гишүүн илүү нэмэх үү, болсон уу? Энхбаяр гишүүнд нэмэлт микрофон өгье.

Б.Энхбаяр: Бас нэг асуудалд анхаарч Боловсролын яам анхаараасай гэж хүсэж байна. 2 жилийн өмнө энэ 26 дугаар хороонд 640 хүүхдийн сургууль Олимп хотхонд барина гээд өнгөрсөн онд нээлтээ хийсэн. Тэгсэн чинь одоо тэр компани нь техникийг нь оруулдаггүй, машин техник орох нөгөө шугам сүлжээнийх нь зөвшөөрөл дээр тухайн дамжиж байгаа хүнээс нь зөвшөөрөл авдаг юм байна. Тэгээд тэрийг нь шантааж хийгээд байдаг. Шүүхэд нөлөөлдөг, шүүгч нарт байр өгсөн сурагтай байгаа. Би бол энийг авлига гэж үзэж байгаа. Энэ асуудлын араас би өөрөө явна. Тэгээд энийг цаг хугацаанд нь тэр компани тийм өгөх боломжийг нь юун дээр Боловсролын яам өөрөө их анхаармаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ тийм үү? Батлут гишүүн.

Д.Батлут: Өглөөний мэнд хүргэе. Нэг хэд хэдэн асуулт байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжтэй холбоотой асуудал дээр нэг асуулт байна. 23 онд нүүрсний экспортод 45 сая, ирэх онд бол 50 сая тоннд хүрч улмаар эдийн засгийн өсөлтийг 6,5 хувьд өсгөх гэж төлөвтэй гэж боловсруулалт хийсэн байгаа. Гэтэл Хятад ард улсын нүүрсний нөөцийн хэмжээ сүүлийн 3 жил жилд дээд хэмжээндээ хүрсэн байна гээд. Тэгээд 22 онд гэхэд нийтдээ 63, 8 сая тонны коксожсон нүүрс бусад орноос импортлож авсан гээд. Тэгэхээр энэ нөхцөл байдал дээр бид нар ер нь дүн шинжилгээ хийж үзсэн юм уу? Яг 50 сая тонндоо бид нар хүргэж нүүрсээ экспортолж чадах уу? Тэгээд тэр нь өөрөө эдийн засгийн өсөлтийг бүрэн дүүрэн хангаж чадна гэж үзэж байгаа юм уу? Цаашиаад нүүрсний үнэ унах нөхцөл байдал байх вий, бас ийм эрсдэлтэй нөхцөл байдал байна гэж дүгнэсэн байна. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч гэж.

2 дугаарт нь эрчим хүчний салбар. Бид нар эрчим хүчний сэргэлт сэргэлтийн бодлого гэж гаргаж ирээд ажиллаж байгаа. Тэгээд эрчим хүчний шинэ сэргэлт гэхээр нэг УЦС, аймгийн ДЦС-ын өргөтгөл, шинэ станц эх үүсвэрүүд барих гээд л олон асуудлууд ярьж байх шиг байна. Тэгэхдээ эрчим хүчнийхээ салбарууд доторх эрүүлжүүлэх процессоор нь хийхгүй юм уу? Өнөөдөр яг уурхай, дулааны станц, эрчим хүчний компаниуд хоорондоо өр авлагатай болчихсон, тарифаа нэмэгдүүлж чадахгүй, бэлэн мөнгөний урсгал хомсодчихсон, цалин хөлсөө нэмэгдүүлж чадахгүй нөхцөл байдалд байгаа.

Тэгтэл нөгөө нэг сэргээгдэх эрчим хүч гэж байгаа шүү дээ. Нэг 9 ААН. Тэгээд эрчим хүчний салбарт 3 хувийн нийлүүлэлт хийхээд бэлэн мөнгөний орлогын 27 хувийг аваад явчихдаг. Тэгээд энэ гэрээнүүдээ яах юм бэ? Би урьдын хэлэлцүүлгээр бас асуугаад тодорхой хариулт авч чадаагүй учраас дахиад асууж байгаа юм. Энийгээ энэ мэтчилний энэ эрчим хүчний систем дотор байгаа болохгүй байгаа зүйлүүдээ бид нар янзалж цэгцлэхгүй юм уу? Энэ чинь 1квт цахилгаан эрчим хүчийг 305-аас 550 төгрөгөөр Монгол Улсын төвийн эрчим хүчний системд борлуулж байгаа шүү дээ. Энийг бид нар яах юм бэ? Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч.

3 дугаарт нь энэ хүний хөгжилтэй холбоотой асуудал бол эрүүл мэндийн асуудал хамгийн чухал. Тэгээд өнөөдөр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо маш сул байгаа гээд дүгнэчихсэн. Цус харвалт, улаан хоолойн хорт хавдрууд гээд элэгний хорт хавдар гээд энэ хорт хавдрын өвчлөлөөрөө дэлхийд нэг, хоёрт орж байгаа ийм нөхцөл байдал байна. Тэгэхээр бид нар нийгмийн соён гэгээрэлтэй холбоотой асуудал, нийгмийн эрүүл мэндтэй холбоотой асуудлыг чухалчилж үзэхгүй бол болохгүй байгаа юм. Тэгэхээр бид яг энэ чиглэл дээр ирээдүйд ямар хэмжээний ирэх онд ямар хэмжээний мөнгө төгрөг тавьсан юм бэ? Энэ чиглэлээр ямар ажил хийхээр

төлөвлөж байгаа юм гэдэг дээр нь хариулт өгөөч.

Эцэст нь ЗГ-аас Аж үйлдвэр технологийн парк байгуулна гээд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт гэрчилгээг нь гардуулаад нэг сүр дуулиантай сайхан арга хэмжээ болсон. Одоо энэ аж үйлдвэр технологийн паркийн хүрээнд хийгдэх ажлууд маань хэр хийгдэж байгаа юм бэ? Хөрөнгө оруулалт нь ямар түвшинд яваа юм бэ? Энэ Монгол Улсыг хөгжүүлэх, хөгжүүлэх хөтөлбөр ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон 24 он гэхэд ашиглалтад орно гэж би ойлгож байгаа. Энэ катодын зэсийн үйлдвэр, зэс хайлуулах үйлдвэр гэдэг маань. Тэгээд энэ нь ажлын явц нь ямар шатандаа явж байгаа юм бэ? Яг энэ хугацаандаа ашиглалтад орж, нийгэмд үр өгөөжөө өгөх үү гэдэг дээр хариулт авъя. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Баттөмөр гишүүн. Тэгээд дараа нь сайд хариулчихъя.

Б.Баттөмөр: Батлут гишүүний асуултад хариулъя. Нүүрс 50 сая тонн амжих юм уу гэж. 2023 оны эхний 4 сарын байдлаар 19,6 буюу 20 сая тонн нүүрс экспортолсон 4 сарын хугацаанд. Тэгээд ингээд үлдэж байгаа 8 сарын хугацаанд бол дахиад 20, 20 гэхэд бол 80, 60 сая нүүрс экспортлох ийм боломж бол байгаа. Тэгээд манай нөхдүүд 50 гэж орж ирсэн. Төсөв дээрээ ч гэсэн тэгж л тооцож төсвийнхөө орлогыг тэгж тооцсон юм байна лээ. Тэгээд энийг 60 гээд ингээд тавьчихаар нөгөө бүх юмнууд энэ ч задраад, нөгөө юу ч задраад төсөв төсвийн хүрээний мэдэгдэл ч задрах гээд ийм төвөгтэй байгаа учраас би бол сануулж байгаа юм. Ер нь энэ 50 гэдэг чинь бол доод талын хэмжээ шүү. Энэ цаашаагаа бол нэмэгдүүлэх боломжтой гэж ингэж үзэж байгаа юм.

Нүүрсний үнэ унаж байна гээд ингээд байгаа юм. Нүүрсний үнэ унаагүй. Монголын нүүрсний үнэ унаад байгаа шүү дээ. Яагаад гэхээр нөгөө л тэр аман

дээрээс нь авдаг, хууль бус юм хийдэг улсууд энэний эсрэг энэ биржийн, Уул уурхайн биржийн энэ нүүрс худалдаж байгааг эсэргүүцээд, цаад талын талтай очиж элдэв бусын яриа хийгээд ийм үйл явдал болоод байгаа байхгүй юу. Тэгээд энэ Улсын Их Хурлаас энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг баталж өгсөн. 40-өөд удаагийн арилжаа явсан, 1,2 сая тонн нүүрс зарагдсан. Дээд талд нь 187 коксжих нүүрс 187 доллар болсон байх. Эрчим хүчний нүүрс 73 доллар болсон. Эрчим хүчний нүүрс бараг 7 дахин, коксжих нүүрс бол 60 доллар 3 дахин нэмэгдсэн байгаа шүү дээ. Энийг эсэргүүцэж байгаа хүмүүс зөндөө байгаа юм.

Тэгээд энд би бас нэг шүүмжлэлтэй Засгийн газарт л хандаж хэлэхэд энэ хуулиа бариад тэр Хятадын талын хүмүүстэй уулзалт хийсэн үү? Энэ ийм хулгай гараад байгаа, энийг бид биржээр худалдана. Мэдээж тэр Хятадын эцсийн хэрэглэгч бол тэр өндөр үнээрээ л авч байгаа шүү дээ. Тэгтэл дунд нь ажилладаг улсууд ийм юм хийгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ уулзалтууд бол учир дутагдалтай яваад байгаа юм уу? Өнөөдөр гээд тэгтэл энэ нүүрсний энэ арилжаанд оръё гэсэн 156 ААН байна гадна, дотнын 156. Биржийн хууль гарахаас өмнө 13 ААН л энэ гэрээг л хийдэг энд ажилладаг байсан, ийм ач холбогдолтой ийм болчхоод байгаа юм л даа. Тийм учраас нүүрсний юун дээр бол тоо хэмжээ дээр бол биелэх боломжтой, 60 хүрэх. Энэ жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээ хараарай. Хүрэлбаатар сайд бид хоёр хоёулаа байна. Энэ он энэ оны эцэст 60 сая болно. Тэгээд та нар 50 сая гээд л ингэж орж ирж байгаа юм. Мэдээж төсөв төлөвлөгөөг хийх үед тоо арай өөрчлөгдөж орж ирэх байлгүй дээ ингэж бодож байгаа.

Дулааны хувьд бол сая Батлут гишүүний хэлж байгаа бол зүйтэй. 10 аймагт дулааны станц байгуулна, шугам сүлжээг нь шинэчилнэ гээд. Тэгээд энэ энэ тэрийгээ яах юм, бид нар бас нэг хөндөөд орхичихсон л доо. ЭХЯ хариулна биз. Тэр

зарим аймгуудын инженерийн шугам сүлжээг чинь хувьд өгчихсөн байгаа шүү дээ. Хувьтай нь хамтраад хийх юм уу эсвэл хувиас нь буцаж төрдөө авч байж хийх юм уу эндээ энэ сая энэ гишүүний асуултад хариулах нь зүйтэй.

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж Ганбаатар, Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Эхлээд тэр Үйлдвэр технологийн паркийн хууль батлагдсантай холбоотойгоор асуултад хариулъя. Шууд Эрдэнэт үйлдвэрийн хувьд бол Эрдэнэт үйлдвэрийн хувьд бол бүх зүйл нь гарчихсан байгаа. Тэгээд Эрдэнэт үйлдвэр бол өөрөө энэ үйл ажиллагаагаа өөрөө өөрийнхөө зардлаар хариуцаад явж байгаа. Эрдэнэт үйлдвэрийн хувьд бол бүх зүйл нь батлагдсан. Бусад байршлууд дээр ялангуяа Дорноговь аймаг болоод бусад говийн аймгууд дээр энэ талбай зарлах ёстой, байршил зарлах ёстой. Тэгэхдээ нөгөө компаниудын гүйцэтгэх өөрсдийнх нь бичиг баримтаа бүрдүүлж өгөх энэ процесс өөрөө удааж байгаа юм. Энийг бид хүлээж байна манай яам.

Эрдэнэт үйлдвэрийн хувьд бол Эрдэнэт үйлдвэрээс өөрөөс нь 100 хувь шалтгаалж байгаа. Эрдэнэт үйлдвэрт бол бид нар бүгдийг нь гаргаад өгчихсөн байгаа. Тэгэхээр Эрдэнэт үйлдвэр маань энэ үйлдвэр технологийн паркийн ажлуудыг өөрийнхөө хөрөнгөөр өөрөө хийгээд гүйцэтгээд явж байгаа. Эрдэнэт үйлдвэрээ бол бид бол саяхан та бас мэдэж байгаа байх. Хайгуулын хувьд бол бид бас өөрөө өөрийгөө авч явах боломжоор нь бараг 6 хайгуулын талбай ЗГ гаргаж өгсөн. Эрдэнэт үйлдвэрийг УУЯ болоод ЗГ бүх талаар дэмжиж байгаа. Үйлдвэр технологийн паркийнх нь явцын хувьд бол Эрдэнэт үйлдвэрийн захирал хариулах ёстой. Эрдэнэт үйлдвэрийг бол ЗГ бол бүх зүйлийг нь батлаад өгчихсөн байгаа гэдгийг нь танд хэлье.

Тэр биржээр зарж байгаа нүүрсний хувьд бол хэлэхэд бол хэн

Баттөмөр гишүүн уулзалт хийж байна уу гэж асуулаа. Ер нь томоохон компаниудтай нь бүгдтэй нь уулзсан байгаа. Тэгээд биржээр нүүрсээ арилжаач, юу биржийн арилжаанд оролцооч гэж манай сайд нар ч гэсэн Хятад ард улсад очиж айлчлахдаа энэ талаар уулзалтуудыг бол хийсэн. Тэгэхдээ яах вэ биржийн нүүрсний хувьд бол худалдан авагч талаас олон жил энэ зүгээр явц нь энэ соёл гэх юм уу, энэ юу гэх юм уу дадал гэх юм уу энэ зүйлээ барихыг өөрсдөө хүсээд байгаа юм. Би их зөөлөн үгээр хэлж байна. Бас хамаагүй хатуу үгээр хэлэх юугүй байна. Гэхдээ бид ямар ч байсан биржээр нүүрсээ зарна. Энэнээсээ хэзээ ч ухрахгүй байгаа. Дотооддоо ч гэсэн бид нарыг бас энэ талаас байр суурь ухрах ухруулах, энийг тийм жоохон онцгүй болгуулах ийм үйл ажиллагаа бол зөндөө явж байгаа.

Тэгэхдээ бол биржийн гол ач холбогдол бол та бол өөрөө сайн мэдэж байгаа. Нүүрс 70, 80 доллар байсан бол бирж одоо 150 доллар хамгийн багадаа. Нүүрсний үнэ тэгэхдээ дэлхийн зах зээл дээр бол унаж байгаа. Бид бол анх бол биржээр нүүрсээ бол 170 доллар хавьцаа зардаг байсан бол 145-150 доллар бол байгаа. Энэ урт хугацааны гэрээ ямар нэгэн байдлаар 70, 80 гэдэг юм уу, 100 гэдэг юм уу ийм доллароор ямар ч нүүрсний гэрээ хийгдэхгүй байгаа. Ялангуяа төрийн компаниуд дээр. Энэ өөрөө хамгийн том ач холбогдол. Бид нүүрсээ их одоо юу гэдэг юм 100 хувь бүгдийг нь юугаар зарна гэдэг ийм зорилт тавьж байгаа ч гэсэн хамгийн гол нь энэ салбарт байж байгаа хулгайг арилгасан, нүүрсний жишиг үнийг тогтоож байгаа. Ширээн доор явж байгаа гэдэг юм уу яаж байгаа энэ бол биржийн хамгийн гол зорилго шүү.

Уулзалтуудыг маш сайн хийж байгаа. Хятадын талаас бол ер нь жоохон хойргодуу бол байгаа. Тэгэхдээ өдрөөс өдөрт сайжирч байна. Чалко болоод Норинко компаниуд энэ биржийн үйл ажиллагаанд оролцох саналуудаа өгсөн. 2, 3 удаагийн үйл ажиллагаанд бол

юу биржийн худалдаанд бол оролцсон. Тэгээд ер нь бол яах вэ манай биржээр зарагдаж байгаа нүүрсийг зарим хүмүүс бага байна, их байна гээд гоочлох муулах ч гэдэг юм уу янз янзын тийм юм ярих тийм түвшиний юмнууд бол байгаа. Бид бол хууль бол 7 сарын 1-нээс хэрэгжинэ. Одоо бид зөвхөн туршилтынхаа үйл ажиллагаануудыг явуулж байгаа. Хууль хэрэгжээд эхэлсэн ч гэсэн бид бол ер нь 24 ондоо багтаад 30 хувьд хүргэх ийм зорилттой бол байгаа гэдгийг хэлье. Угаасаа энийг бол хууль.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Батлут гишүүн болсон уу? Эрүүл мэндийн чиглэлээр хэн хариулах вэ? Эрүүл мэнд, эрчим хүчний чиглэлээр асуусан асуултад тэр 5 дугаар микрофон дээр суугаад, эрүүл мэндийнхэн байна уу? 5 дугаар микрофон, нэр, албан тушаал хэлнэ шүү.

Л.Лувсан: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга Лувсан гэдэг хүн байна. Эрхэм гишүүний асуултад хариулъя. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх асуудалд хэдий хэрийн хэмжээний мөнгө төсөвлөж байгаа вэ гэсэн асуулт байна. Уламжлалт вакцины зардалд 20 тэрбум төгрөг төлөвлөж байгаа. Халдвартын тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 16,3 тэрбум төгрөг. Эрт илрүүлгийг эрчимжүүлэх, анхан шатын тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлд 3,7 тэрбум төгрөг нэмэхээр 24 оны төлөвлөгөөнд ийм мөнгө төлөвлөж байгаа нэмэлтээр.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Дараагийн гишүүн, тодруулъя. Батлут гишүүн тодруулъя.

Д.Батлут: Асуултууддаа бас бүрэн дүүрэн хариулт авч чадахгүй байна. Яах вэ би нүүрсний асуудлыг ойлгож байгаа юм. Би энэ нөгөө энэ тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжтэй холбоотой асуулт асуучихсан байхгүй юу. Энд нүүрсний үнэ унах магадлал байна. Дээрээс нь энэ чинь зах зээлийн зарчмаар явж байгаа шүү дээ. Эрэлт, нийлүүлэлт

дээр л тогтоож байгаа. Тэгээд Хятад маань үндсэндээ манайх Хятад руу л экспортолж байна. Хятад маань үндсэндээ бүрэн хангалттай нүүрсний нөөцтэй болчихсон байна, ингэснээрээ бас нүүрс авах тэр үйл ажиллагаа саарах нөхцөл байдал үүсэх нь. Нүүрсний үнэ жоохон унах нь. Ингэхээр бид нар энэ 50 саядаа хүргэж экспортолж чадах уу? Дээрээс нь энэ эдийн засгийн өсөлтийг 6,5-даа хүргэж чадах уу л гэдэг асуудал байхгүй юу гол нь. Тэгэхээр энэ дээр тодорхой нэг байр суурь, төлөвлөлт, ярьж хэлж байгаа зүйлүүд юу байгаа юм бэ тэрийг л нэг хариулаад өгчихвөл болж байна л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн сайд хариулъя. Энэ юу яасан шүү дээ бид нар нөгөө хууль хэрэгжээд одоо бол туршилтын шугамаар явж байгаа шүү дээ. Тэгээд нэг жоохон жигдрэхгүй байгаа талын л юм асуугаад байх шиг байгаа юм.

Ж.Ганбаатар: Ойлгож байна. Энэ манайхан бас нөгөө Австралийн нүүрс их чөлөөтэй болсон, Австралиас нүүрсний нөөц ихсэж байгаа гээд байгаа. Тэгэхдээ Австралийн ирж байгаа нүүрсний ихэнх бараг 90 гаруй хувь нь дандаа эрчим хүчний нүүрс Хятад улсад нийлүүлэгдэж байгаа юм. Тэгэхээр манай гаргаж байгаа нүүрсний 99 хувь нь коксожсон нүүрс гаргаж байгаа. Тэгэхдээ манай гаргаж байгаа коксожсон нүүрстэй өрсөлдөхүйц нүүрс бол ер нь бол хамгийн гол өрсөлдөхүйц нүүрс бол Оросын холбооны нүүрс байгаа Батлут гишүүнээ. Тэгэхээр нөгөө Индонез болоод Австралийн нүүрсийг нөгөө хориггүй болгочихлоо, тэгээд энэ хангалт нь ихэсчихлээ, манай нүүрс багасчих вий гэдэг энэ болгоомжлол бол шууд эрчим хүчний нүүрсний өрсөлдөөн шүү гэдгийг бас манайхан бас ялгаж салгаарай гэдгийг хэлье.

Үнийн хувьд бол УУЯ зүгээр бид бол Сангийн яам болоод Эдийн засгийн хөгжлийн яаманд гаргаж өгөхдөө 137 доллар гэж гаргаж өгсөн. Ирэх жилийн төлөвлөгөөг юуг прогнозыг. Бид бол их

олон талаас нь харж байгаад. Яг таны хэлж байгаа бол үнэн. Нүүрсний үнэ унах магадлал.../минут дуусае/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхийдөө ойлголттой байх ойлголт ойлгомжтой байх тийм. Таны хийж байгаа ажлыг ер нь ойлгож, таны хийж байгаа ажлыг их сайн ойлгож байгаа ер нь. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Надад нэг 5 асуулт байгаа юм. 1 дүгээр асуулт бол төмөр замтай холбоотой ЗТЯ-ныхан хариулаарай. Ингээд байшин барихаар чинь бид нар уг нь эхлээд сууриа бариад, дараа нь каркасаа барьдаг юм шүү дээ. Тэгээд тэр 21 онд ч хэлж байсан, 22 онд ч хэлж байсан уг нь ингээд холболтын цэгээсээ наашаа төмөр замаа татаж болдоггүй юм уу л гээд байхад асуудалгүй л гээд байсан. Одоо ингээд ирэх жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд чинь 650 тэрбум төгрөг ингээд холболтын цэг дээр ачиж буулгах терминал гээд тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ одоо хүртэл нөгөө төмөр зам нь бариад дуусчихсан мөртөө нэг ч тонн нүүрс гардаггүй, гаргадаггүй. Тэгээд нэг ийм эдийн засгийн хувьд ингээд хэн ч харсан нэг ийм үр ашиггүй, ийм зохион байгуулалтын ажлаа ингээд дандаа нөгөө талаас нь хийдэг энэ асуудлыг ер нь цаашидаа яг хэн хариуцаж, хэн зангидаж явж байх вэ? Тэгээд ирэх жил энэ терминалууд нь баригдаж дуусах уу, үгүй юү 1 дүгээр асуудал.

2 дугаар асуулт болохоор энэ стратегийн ашигт малтмалын ордуудыг баялгийн сантай холбоно гэсэн ийм асуудлыг энэ ажлын хэсэг оруулж ирсэн байна л даа. Ер нь дэлхий дээр стратегийн ашигт малтмалын орд гэж юм байдаггүй юм л даа. Тэгээд манайх шиг, тэр тусмаа ийм зам тээврийн, ингээд логистикийн асуудалтай байдаг орны хувьд бол логистиктоо тааруулаад стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын төрлөө гаргаж ирэх ёстой байхгүй юу. Магадгүй тэр онгоцоор гарах боломжтой. Энэ 50 сая тонн нүүрс

гаргана гээд байгаа энэ 50 сая тонн нүүрсний оронд 10 сая тонн дээр нь ядаж 400, 500 долларын нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүн гарах боломжтой. Ийм бүтээгдэхүүнээ хөгжүүлэх алхмуудаа хийж эхлэхгүй юм уу гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дугаар асуудал болохоор энэ эрчим хүчтэй холбоотой. Энэ эрчим хүчний хараат байдлаас ер нь яаж гарах гэж байгаа юм бэ? Ерөөсөө ингээд жил жилийн төлөвлөгөө л харах юм. Нөгөө л нэг Багануур, нөгөө л нэг Бөөрөлжүүт. Тэгээд тэр нь ерөөсөө ажил нь явдаггүй. Хэзээ эд нар нь ашиглалтад орж дуусах юм бэ? Энэ Улаанбаатар хот ер нь хэзээ яг энэ дулааны асуудлаа ингээд асуудалгүй шийддэг болох юм бэ? Яг дулааны сүлжээ дагаж энэ орон сууцын хорооллууд чинь босоод байгаа байхгүй юу. Тэгээд тэрнээсээ болоод энэ түгжрэл чинь бий болчихоод байгаа шүү дээ. Тэгээд тэр газар нь илүү үнэтэй болчихдог.

Энхбаяр гишүүний яриад байгаа манай тойрог дээр ч гэсэн ялгаагүй асуудал нь юундаа гэхээр яг тийм түгжрэлүүд тийм шинэ хотхонууд сургуулиа барьдаггүй, цэцэрлэгээ барьдаггүй. Тэгээд яг мөнгөө хөөгөөд баахан байшингууд барьчхаад байгаа. Тэгээд одоо хойноос нь хөөцөлдөнгүүт сургууль, цэцэрлэгийн асуудлыг нь хойноос нь хөөцөлдөж явдаг. Энэ чинь дараалал нь алдагдчихаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бас хотоос би бас хариу авчихмаар байна. Боловсролын яамнаас. Энэ 24 онд энэ манай тухайлбал 3 хороо дээр сургууль байхгүй.

Нөгөө нэг алдарт Алтай хотхон, Эрэн хотхон, одоо хороодоор нь ярих юм бол 20, 24, 25. Хүн амаар нь харвал тэнчээ бараг 50 мянган хүн амьдарч байна. Сургууль байхгүй. Хүүхдүүд нь том, том төв зам дагаж гарч энэ сургууль, цэцэрлэгтээ явдаг. Тэгээд энэ асуудлыг ерөөсөө шийдэж өгдөггүй юм. Энэ дээр би хариу авчихмаар байна. Нэгэнт л одоо төлөвлөгөө ярьж байгаа юм бол

төлөвлөгөө дээр хэрхэн яаж тусгасныг чинь сонсмоор байна.

Сүүлчийн асуудал бодлогын 2 дугаар тэргүүлэх чиглэл гэдэг дээр бид нар гадаадын хөрөнгө оруулалт гээд 4 тэрбум төгрөг тавьсан байна л даа. Биш ээ доллар тавьсан юм байна. Энэ дээр яг бодит ер нь төсөл байгаа юу эсвэл энэ ашигт малтмалын хайгуулын юунуудаа нээж өгөх гээд байна уу? Энэ тоо ер нь хэр бодитой гэдэг асуух гэсэн юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эхний асуудал Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД Батболд 7 номер.

С.Батболд: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Холболтын цэгүүдийн асуудал яагаад энэ удаад байна вэ гэхээр инженер техникийн ажилчдын хувьд бол 2 талынхан бол тохирчихсон байдаг энэ боомтуудын. Энийг Гадаад хэрэг харилцааны яамны шугамаар энийг тохиролцох асуудлууд бас явагддаг. Энэ процессууд бол ер нь бол явагдаж байгаа. Гашиун сухайтынх бол тохирчихсон, Шивээ хүрэнгийнх бол тохирчихсон гээд ингээд явж байгаа. Энэ тохиролцооны асуудлаасаа болоод энэ холболтууд жосоохон удсан зүйл байгаа. Гашиун сухайт Ганц мод чиглэлийн төмөр замын энэ холболтын ажил бол ирэх жил бол дуусахгүй. Барилгын ажил бол энэ жил бид нар ТЭЗҮ зураг хийгээд эхлүүлэхээр зорьж байгаа. Гашиун сухайтын терминалын ажил бол энэ жилдээ бол дуусчихна. Шивээ хүрэн Сэхээ чиглэлийн төмөр замын ажил өчигдөр ЗГ-ын, уржигдар ЗГ-ын хуралдаанаар орсон. Энэ холболтын төмөр замын ажил терминалын ажил энэ жилдээ бол дуусна.

Ж.Бат-Эрдэнэ: Тавинбэх дарга ТНБД Тавинбэх 5 номер дээр суучих. 5 номер ажлын хэсгийн 5 номер, Батболд наад 7 номероо унтраа.

Н.Тавинбэх: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцын барилга

угсралтын ажил өнөөдрийн байдлаар 30 орчим хувьтай явж байна. 24 оны 4 дүгээр улиралд багтаж ашиглалтад орохоор байгаа. Ажлын явц бас сайн явж байгаа гэдгийг хэлье. Хувийн хэвшлийн үндэсний хувийн хэвшлийнхэн энэ ажлыг гүйцэтгэж байгаа. Багануурын хувьд бол концесс эзэмшигч өөрчлөгдөж байгаа. Энэ сарын дундуур ирж уулзалт хийхээр тохироод байгаа. Тэгээд энэ уулзалтаар энэ ажил цаашидаа хэрхэн үргэлжлэх талаар тодорхой болно.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь дараагийнх нь нийслэлийнхэн, нийслэлийнхэн хариулах уу? 5 номер дээр. Та хэд энэ асуултдаа тодорхой хариулахгүй бол.

Ж.Сандагсүрэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. 2022 оны эцсээр бол нийтдээ бид 4 сургууль, 2 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор 13 цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулсан байгаа. Өнгөрсөн 2022 онд цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийслэл ЗГ нийлж 200 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн. Үүнээс нийслэлээс бол 100 тэрбум төгрөгийг дангаар нь шийдвэрлэсэн байгаа. Нийтдээ 146 тэрбум төгрөг 2022 онд энэ асуудлуудад зарцуулагдсан байгаа юм.

Зүгээр одоо яг Ганхуяг гишүүний ярьж байгаа энэ дүүрэг дээр асуудал нь юу байна вэ гэхээр газартай холбоотой юм асуудал нь нэлээн хүнд байдаг. Нийслэлийн түвшинд өнөөдөр тавигдаж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын дийлэнх хэсэг нь газар чөлөөлөлттэй байгаад байдаг. Нийслэл дээрх газар чөлөөлөлтийн мөнгө нь хангалтгүй байдаг нэг том шалтгаан байна. Нийслэл өөрсдийн нөөц бололцоогоор газар чөлөөлөлтөд санхүүжилт хийж шийдэж байгаа боловч энэ нь бол яг энэ барилгажсан ийм газрууд бол хүнд нөхцөл байдалтай байдаг. Эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд түрүүн хариулчихсан. Мэдээж хотын зүгээс дэд бүтцийн чиглэлээр 6 дэд төв дээр шинэ дэд төвүүдийг төсөл хөтөлбөрийн болон орон

нутгийн санхүүжилтээр шийдэж ингэж явж байгаа. 2023 онд бид дахиад 2 дэд төв дээр бие даасан эх үүсвэрийг ингээд шийдвэрлэхээр ингээд зориод ажиллаж байн. Тэгэхээр энэ бол саяын хэлсэн тэр төвлөрлийг сааруулах зах хороолол руу сургууль, цэцэрлэг барих энэ ажил дээр бол нэлээн дөхөм болох ийм ажлууд байгаа гэж. Болох уу?

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн, Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энд энэ стратегийн орд гээд байдаг уу гээд яах вэ танин мэдэхүйн шинжтэй зүйл ярьж байна. Тэгээд яах вэ. Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 6.1.1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж байгаа юм л даа. Ордыг бол 6.1-д ордыг доор дурдсанаар ангилна гээд 6.1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж байгаа юм. Энэ хуулийн хүрээнд ингэж авч үзсэн юм. Энийг яагаад энэ юунд ингэж оруулсан гэхээр энэ манай ажлын хэсэгт нэг эрдэмтэд орсон юм. Эрдэмтэд бол ямар санал тавьсан гэхээр энэ маш олон жил энэ Хармагтай, Асгат гээд 7, 8 орд байна, ингээд дараад суугаад байх юм уу энэ чинь одоо. Чаддаг улсуудад нь өгөөд ашиглуулбал яасан юм. Төр энийгээ тэр тодорхой хөрөнгө оруулалт хийвэл яасан юм. Гадаадын том хөрөнгө оруулагчдад санал болговол яасан юм гээд ийм санал манай эрдэмтдээс гаргасан юм. Тэгээд энэ дээр бол ингээд энэ тогтоолын төсөлд оруулсан юм л даа. Энд ингээд хийхэд бол бэлтгэлийг хангахад бол төсвөөс нэг их хэмжээний мөнгө гараад байх ийм гарахгүй. Ямар ч байсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль Их Хуралд өргөн баригдсан байгаа шүү дээ. Ганхуяг гишүүн сайн мэдэж байгаа, мэдээж бараг ажлын хэсэгт нь орсон байх. Тэгээд энэ сантай бол энэ баялаг бол тодорхой хэмжээгээр холбогдоно. Энэ утгаараа энийг ингэж оруулж өгсөн юм энэ заалтыг.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн тодруулъя нэг минут.

Х.Ганхуяг: Яг сургуультай холбоотой асуудал дээр яг хариулт авчихмаар байна Боловсролын яам, Нийслэл хоёроос. Энэ Алтай хот 20, 24, 25 дугаар хороонууд дээр ирэх жил сургуулийн асуудал шийдэх үү, газрын асуудлыг нь шийдэх үү?

2 дугаар асуудал болохоор сая нөгөө стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал гэдэг маань одоо ингээд харах юм бол Хятад улс бол газрын ховроо ингээд 70, 80 хувь нь атгачихсан сууж байна. Латин Америк бол батареин түүхий эдүүдээ ингээд атгачихсан сууж байна. Тэгээд тийшээгээ ингээд хөрөнгө оруулалт хийдэг, боловсруулалт нь хийгээд, тэгээд тэрийгээ хөгжүүлээд явдаг. Манайх тийм юм хийхгүй бол одоо ингээд зүгээр л ингээд зүгээр сая тонн нүүрсээр нь ингээд л тэдэн сая тонн нүүрс зарна, эдэн сая тонн нүүрс зарна гэхээр чинь хөгжихгүй байгаад байхгүй юу. Тэрийг чинь бол ойлгож байна. Таны нөгөө энэ ашиглах цаг нь болчихсон, болчихсон. Гэхдээ бид нар яг энэний хажуугаар манайх шиг ийм хязгаарлагдмал ийм тээвэртэй газар бол стратегийн ашигт малтмалын төрлөө гаргаж ирэх хэрэгтэй байгаа байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Улаанбаатар хотынхон тэр саяын сургуультай холбоотой бүүр тодорхой асуулт асуулаа шүү дээ. Боловсролын яам 5 дугаар микрофон дээр очъё. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Л.Цэдэвсүрэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Түрүүн Энхбаяр гишүүний асуултад хариулахдаа энэ нийслэл дэх 3 ээлжийн асуудлыг би бас хөндсөн байгаа. Өнөөдрийн байдлаар Хан-Уул дүүрэгт 12 сургууль дээр 154 бүлэг дээр бол бүлэг дүүргэлт хэтрэлттэй, хүүхдийн ачаалал хэт их байгаа гэсэн ийм судалгаа гарсан. Тэгээд энийг бол ер нь нийслэлийн хэмжээний 54 сургуулийн бүлэг дүүргэлтийг өөрчлөх зорилгоор бид

нар энэ оны одоо энэ хэлэлцэж байгаа төлөвлөгөө дээр бол ирэх жил 24 сургуулийн асуудлыг бол тусгасан байгаа. Яг одоогийн байдлаар бол 2022 онд Буянт-Ухаа 2 дээр 1200 хүүхдийн суудалтай нэг сургууль ашиглалтад орсон.

Ж.Бат-Эрдэнэ: БГД-ийн тухай асуугаад байна шүү дээ. БГД шүү.

Л.Цэдэвсүрэн: БГД дээр 7 сургуулийн 63 бүлгийн бүлэг бол бүлэг дүүргэлт ихтэй, 54 сургуульд маань орчихсон байж байгаа. Тэгээд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Байна уу? Баярлалаа. Би хоёрхон асуулт асууна. 1 дүгээр асуудал бол энэ Эрдэнэс таван толготой холбоотой асуудал байна. Энэ 2024 онд Эрдэнэс таван толгойг олон нийтийн болгох уу гээд. Ер нь энэ Эрдэнэс таван толгойг юу гэдэг юм нөгөө 2013 оноос хойш төрсөн хүүхдүүддээ нөхөж өгөөд, тэгээд үлдэгдэл 20 гаруй хувийг нь ч гэдэг юм уу, 51 хувийг нь төрд авч үлдээд, бусдыг нь олон нийтийн болгох ажлыг зохион байгуулах уу 2024 онд? Тэгэхгүй бол энэ Эрдэнэс таван толгой дээр гарч байгаа хулгай ч гэдэг юм уу зэлгий ч гэдэг юм уу ийм юм дуусахгүй л дээ. Жилийн жилд л энэ хулгай зэлгийний асуудал яригдаж явна. Тийм учраас олон нийтийн болгох, олон нийтийн хяналттай болгох энэ асуудлыг 2024 ондоо шийдэж явах уу гэдэг асуудлыг тавьж байна.

Бид бол юу гэдэг юм энэ хувийн хэвшлийн банкнуудыг бол олон нийтийн болго гээд шахаад, олон нийтийн болгоод явж байгаа шүү дээ. Харин ч амжилттай явж байгаа. Харин өөрсдийнхөө төрийн өмчтэй энэ юу гэдэг юм компаниудаа олон нийтийн болгох ажил дээр л нэлээн хойрго хандаад байна уу гэсэн ийм бодолтой байгаа шүү. Тэгээд орж ирсэн орлогоор нь Таван толгой цахилгаан станцаа барьдаг ч юм уу, энэ нийслэл болон Улаанбаатар

хотод тулгамдаад байгаа замаа барьдаг ч гэдэг юм уу энэ асуудал дээр нэг анхаарал хандуулж ажиллах уу гэдэг ийм асуулт байж байна.

2 дахь асуудал бол үйлдвэр технологийн паркийн асуудал 2022 оны 8 сарын 1-нд батлагдсан. Тэгээд Үйлдвэр технологийн паркийн хууль дээр Үйлдвэр технологийн паркийн зөвлөл гэж байгаа. Зөвлөл нь хөгжлийн төлөвлөгөөгөө батална. Зөвлөл нь техник, эдийн засгийн үнэлгээгээ батална. Байгаль орчны яам нарийвчилсан болон нөлөөлөх байдлын үнэлгээгээ хийнэ гээд. Тэгээд 5 бүсэд томоохон хэмжээний үйлдвэр технологийн парк байх юм байна гээд. Ганбаатар сайд бол их сайн мэдэж байгаа, анх санаачлаад явж байсан. Тэгээд Эрдэнэт, Таван толгой энэ нүүрсний бүлэг ордыг дагалдуулаад Дорноговь аймгийн нефть боловсруулах үйлдвэрийн Алтаниширээт үйлдвэр технологийн Алтаниширээт нефтийн үйлдвэр дагалдуулсан үйлдвэр технологийн паркийг байгуулах нь зөв юм байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ард үйлдвэр технологийн паркийг байгуулах нь зөв юм байна. Дорноговь аймгийн Хөвсгөл сум дээр байж байгаа 4 том бүлэг орд байж байгаа нүүрсний. Энийг төмөр зам татсантай холбогдуулан Гэрэлт говь үйлдвэр технологийн парк гээд ингээд хүнд үйлдвэрлэлийн үйлдвэр технологийн паркаа байгуулаад явах нь зөв гээд.

Одоогоор Уул уурхайн яаман дээр ажиллаж байгаа Үйлдвэр технологийн паркийн зөвлөлөөр Эрдэнэтийн асуудал Алтаниширээт үйлдвэр технологийн паркийн асуудал, Гэрэлт говь үйлдвэр технологийн паркийн асуудал Хөгжлийн зөвлөлөөр ороод батлагдсан байж байгаа. Бүгд техник, эдийн засгийн үнэлгээгээ бол одоо хийчихсэн байж байгаа. Харамсалтай нь энэ Гэрэлт говь үйлдвэр технологийн парк энэ дээр мартагдаад, орхигдоод бас ороогүй байна. Энэ дээр бас Ганбаатар сайд бас оруулж өгөх талаас нь бас анхаараач гэдэг асуудал байж байна.

3 дахь асуудал бол энэ Боловсролын яамтай холбоотой. Энэ 3 ээлжийн хичээлүүд их боллоо. Тухайлбал Дорноговь аймгийн Замын-Үүд сум дээр 3 ээлжээр хичээллэж байна. Энэ жил 640 хүүхдийн сургууль ашиглалтад орно. 640 хүүхдийн сургууль орсон ч гэсэн энэ 3 ээлж бол хэвээрээ байх юм шиг байна. Тэгээд энэ БНХАУ-аас буцалтгүй тусламжаар ингээд сургууль, цэцэрлэгүүд бариад байх юм. Тэгээд нөгөө хил залгаа Замын-Үүдийн олон улсын боомт дээрээ энэ улсын хөрөнгө оруулалтыг ерөөсөө шингээж өгөхгүй юм. Тэгээд холбогдох газруудтай нь уулзах юм. Танай Монгол Улсад тодорхой хэмжээний дэмжлэг тусалцаа өгч сургууль, цэцэрлэг барьж байгаа. Тэгээд харамсалтай нь яагаад Замын-Үүд дээр баригддаггүй юм бэ гэдэг асуудлыг бол салбар яамнуудаасаа асуу гэдэг ийм асуудал тавиад байж байна. Тавиад байдаг. Тийм учраас энэ 2024 онд юу гэдэг юм энэ Дорноговь аймгийн Замын-Үүд сум дээр ялангуяа энэ ЕБС, сумын сургууль, цэцэрлэг барих энэ асуудлыг бас.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Эхний асуултад Ж.Ганбаатар сайд хариулах уу?

Ж.Ганбаатар: Уучлаарай. Эхний асуудлын хувьд бол манай Байнгын хороон дарга ер нь өөрөө маш сайн мэдэж байгаа. Одоо ер нь үлдээд байгаа гол зүйл бол үйлдвэр технологийн паркийн хувьд бол бид ер нь байршлуудыг зарлах ёстой юм. Зөвлөлийн хийх ёстой ажлууд бол ихэнх нь дуусчихсан. Тэгээд ер нь тэгэхдээ байршлыг зарлах гэдэг дээр Энхтүвшин дарга бас сайн мэдэж байгаа. Энэ бол хуулиар олгогдсон бас нэлээн олон тийм хөнгөлөлт чөлөөлөлтийн тийм бас нэг давуу байдлууд бол байгаа. Тэгэхээр тэрийгээ хуульд заасан тэр бүрдлүүд бас хангагдаж өгөхгүй, тэр компаниуд нь хуульд заасан бичиг баримт бүрдлүүдээ гаргаж өгөхгүй тэгээд, өгөхгүй ч юу байх вэ дутуу байгаад байгаа юм. Тэгээд бид энийг л хүлээж байгаа юм. Тэгээд хуулиас даваад шууд юу гэдэг юм бүрдэл дутуу байхад нь ЗГ-аар ороод байршлуудыг

зарлаад явчих ийм боломж бол байхгүй байгаа.

Тэгэхээр энэ бүрдлүүдээ хангахыг Уул уурхайн яам хүлээж байгаа гэсэн үг даргаа. Тийм учраас бид Үйлдвэр технологийн паркийг бол угаасаа бид дэмжиж баталж байгаа. Гэхдээ энэ нөгөө дагаад нэлээн том, том хөнгөлөлт чөлөөлөлтүүд байгаа учраас тэр бичиг баримтын бүрдэлт болоод хангагдах тэр шаардлагууд бас нэлээн байгаа. Энхтүвшин дарга энийг бол сайн мэдэж байгаа. Тэр орхигдсон зүйлүүдийг дэмжихэд бэлэн байна гэдгээ хэлье. Манай яам дэмжиж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн асуулт Боловсролын яамнаас асуусан байх. Таван толгой олон нийтийн болох тал дээр Хүрэлбаатар сайд хариулах уу? Бодлогын хүрээнд. Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Тийм. Би ер нь Байнгын хороон дарга байхдаа Бат-Эрдэнэ даргад бол их минут их тийм тавиу өгдөг байсан юм. Манай Бат-Эрдэнэ дарга ч бас хатуу байна. Тэгээд юу байна, харин тийм байна, ойлгож байгаа. Ер нь бол олон нийтийн болгох ёстой. Энийг бол ЗГ барьж байгаа. Ер нь ЗГ-ын хуралдаан болгон дээр бол Ерөнхий сайд бол энэ талаар үүргүүдийг өгч байгаа. Тэгэхдээ бас онц байдал зарласан, дотоод асуудлууд нь шийдэгдээгүй тэгээд ийм байгаа асуудлууд бол байна. Ер нь тэгээд яах вэ банкныг бас олон нийтийн болгох гээд явж байхад бол үүсэж байсан бэрхшээлүүдийг өнөөдрийн Байнгын хорооны гишүүд бас нэлээн сайн ойлгож байгаа байх. Тэр үед би өөрөө Байнгын хороон дарга байсан. Тэгээд ер нь ямар, ямар бэрхшээлүүд байсан билээ, бид ер нь ямар туршилагаар тэрийг хийсэн билээ? Тэгээд яах вэ таны хэлж байгаа бол санаа бол зөв. Мэдээж олон нийтийн болгох бага ч гэсэн хувийг нь олон нийтийн болгох энд нэг цонх оруулах.

Ер нь бол тэгээд ЗГ дээр бол би бол хэлж байгаа юм л даа тэр хувьцаа энэ тэрийг нь бол шууд ЗГ-ын шийдвэрээр

тараах гэдэг юм уу, мөнгө хуваарилах байр суурийг бол би бол эсэргүүцдэг. Энэ бол одоо өөрөө мэдэх ёстой. Өөрөө одоо тийм их өртэй байж тэгээд янз янзын байдлаар ийш тийшээ мөнгө төгрөг тараах гэдэг юм уу, халамж ийш тийшээ яваад л, эхлээд өөрийнхөө асуудлуудыг өөрөө шийдэх ёстой. Тэгээд хэрвээ таны хэлж байгаагаар энэ олон нийтийн болоод хяналт нэмэгдээд ирэх юм бол өнөөдрийн байж байгаа энэ ЗГ-аас тавьж юу хэрэгжүүлж байгаа энэ бодлого маань улам сайжраад л явна. Цаашидаа гарах асуудлууд сайн. Энэ бол тэгээд л угаасаа бид нар ямар бодоод олчихсон нэг их тийм мундаг асуудал биш. Энэ бол дэлхийн жишиг шүү дээ. Тийм учраас бол ЗГ олон нийтийн болгох дээр нь бол яг тантай адилхан байр суурьтай байгаа гэдгийг хэлье. Энийг хэрэгжүүлэхийн төлөө бид ажиллаж байгаа. Тэгэхдээ бас хийх ажлууд бол нэлээн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Өнөөдрийн хуралдаанд Эдийн засгийн хөгжлийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нар орчихсон байгаа шүү, оролцож байна. Тэгээд 2 дахь асуудал Боловсролын яам, 5 номер Цэдэвсүрэн дарга. Тэгээд жоохон шахаад явъя, одоо чуулган эхлэх гээд байна.

Л.Цэдэвсүрэн: Ачаалал өндөртэй сургуулиуд буюу 3 ээлж рүү шилжүүлж шилжих эрсдэл үүсчихсэн байгаа сургуулиуд дээр бид нар бодлогоор 5 төрлийн арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа. Одоо баригдаж байгаа бүх барилгуудаа бол ашиглалтад оруулж шинээр хэрвээ газрын асуудал нь шийдэгдсэн тохиолдолд шинэ барилгын асуудлуудыг бол тавина гэж байгаа. Барилга байгууламжийг бол түрээслэх асуудлыг бас нэлээн сайн судалж байна. Яг сургалтын зориулалтын барилга байшингууд байвал цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлсэнтэйгээ ижил одоо энэ 3 ээлж рүү шилжих гээд байгаа барилгууд дээр түрээсийн асуудлыг яаж шийдэх вэ гэдэг хувилбаруудыг бас судалж байна. Ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц зохион байгуулалтын

өөрчлөлтийг хийхээр бас төлөвлөж байгаа. Сургуулиудын хэв шинжийг бага, дунд, ахлахаар нь төрөлжүүлэх боломж юу байна гэдгийг судалж, энэ дээр бол тодорхой шийдлүүдийг бас гаргаад явж байна. Сургуулиудын дотоод нөөц бололцоог бас өөрчлөх, ялангуяа доторх анги танхимын зохион байгуулалт сул байгаа талбайнуудыг хэрхэн яаж өөрчилж бол болох вэ гэдэг асуудлуудыг бас судалж байна.

Хосолсон сургалтыг зохион байгуулахаар бас төлөвлөж байгаа. Энэ бол танхимын болон цахимын гэсэн үг. Яг өнөөдрийн байдлаар 2024 оны төлөвлөгөөний төсөл биш ээ, Төсвийн төсөл яригдаагүй байгаа учраас Дорноговь аймагт бол тийм шинэ сургууль барина, барихгүй гэдэг амлалтыг бол шууд өгөх боломжгүй байна. Одоогоор бол төлөвлөгдсөн зүйл байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүн санал хэлэх гэж байна уу? Тэгээд хэдүүлээ завсарлаадахъя. Үндсэн хууль хэлэлцэх гээд чуулган эхлүүлчхээд, тэгээд 11 цаг хүртэл завсарлачхаад ороод ирье хэдүүлээ. Ганибал гишүүн.

Н.Ганибал: Монгол Улсын энэ хөгжлийн төлөвлөгөө гэж бид нарт ер нь энэ Монгол Улсын өнөөдрийн хөгжихгүй байгаагийн хамгийн чухал асуудал бол мэдээж ямар нэгэн төлөвлөлтгүй, тогтсон бодлогогүй явдгаас болоод өнөөдрийн бид Монгол Улсын бас хөгжил хөгждөггүй юм. Хүрэлбаатар сайдаа. Тэгэхээр ер нь зүгээр тийм, хөгжлийн гол асуудлууд дээр зүгээр хөдөө аж ахуйн салбар дээр хэд хэдхэн асуудал яриад байх юм. Монголчууд бид бүхэн бас ингээд ноолуураа Европын зах зээл дээр гаргадаг энэ чадамж суучихлаа. Энэ жил бас ноолуурыг бол одоо Монголын үндэсний компаниуд өөрсдөө авч угааж, самнаж гаргадаг ийм чадамжтай болж байна. Энэ дээр бас Ханбогд кашмер гээд компанийг бас онцгойлон бас магтмаар байна. Өмнө нь бол бид Хятадын зах зээлтэй бүтээгдэхүүнээ нийлүүлээд, тэдний гаргасан Европ руу гаргасан

сувгаар бүтээгдэхүүнээ зах зээл Европын зах зээл рүү гаргадаг байсан бол Монголчууд өөрсдөө хувийн компаниуд маань энэ арга хэмжээгээ авч чаддаг болсон.

Тэгтэл яг нөгөө бодлогын салбарын яам маань тухайн үед саяхан нэг техникийн зохицуулалтын асуудлыг оруулж ирээд нөгөө малчдадаа ачаалал үүсэх байдлаар ингээд энэ бодлогыг ноолуур дээр бодлого оруулж ирэхийг санаархсан. Тэгэхдээ энийг бас Эдийн засгийн хөгжлийн яамтай болсноороо энэ асуудал дээр зөвөөр олж харж, тэрийг арай өөр шатад явуулсан байх гээд бодож байгаа юм. Тэр шийдвэрүүд тэгж гарч байх шиг байна лээ. Тэгэхээр бид нар бол дараагийн зах зээлээ эцсийн зах зээлээ олж авах тэр бодлогуудыг бид нар хөдөө аж ахуйн салбар дээрээ сайн гаргах ёстой. Энэ дээр бас арьс ширний асуудал байгаа юм. Одоо энэ төлөвлөгөө дээр болохоороо Дарханы арьс ширний паркийн үйл ажиллагааг явуулна гэсэн байна. Дээрээс нь Эмээлтэд бас нэг парк яригдаад ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ болгон маань эргээд нөгөө арьс ширний үйлдвэрлэгч нар дээрээс нь хамгийн их түүхий эд бэлтгэдэг малчдад энэ бодлого болгон ямар нэгэн байдлаар очоод байгаа юм.

Тэгэхээр бид нар үнэхээр тэр Дарханы арьс ширний паркийг явуулах боломжтой бол явуулмаар байгаа юм. Энэ уг нь бол тухайн үед танилцаж байсан л даа. Энэ төсөл бол эцсийн бүтээгдэхүүн болгох зах дэлхийн зах зээлийн судалгаа энэ тэр гээд маш олон судалгаа дээр суурилж уг нь эхэлж байсан. Тэгээд яах вэ явцын дунд ямар нэгэн техникийн алдаанууд болоод өнөөдөр сунжирч байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхдээ энийг нэгэнт төлөвлөгөөнд оруулж л байвал тэгээд л явуулаад, дээрээс нь Эмээлт гээд л ороод ирдэг. Нэг нь дуусаагүй байхад нөгөөдөх нь ороод ирдэг. Нөгөө арьс ширний үйлдвэрүүд, үйлдвэрлэгч нар маань арьс ширний үйлдвэрүүд маань энэ хоёрыг

хүлээгээд шинээр юу ч хийж чадахгүй ингээд цаг хугацаа өнгөрөөд байгаа юм.

Дээрээс нь энэ хөгжлийн төлөвлөгөөг ажлын хэсгээс энэ зарчмын зөрүүтэй саналаар улсын санхүүжүүлэх эх үүсвэрүүдийг нь улсын төсөв гэж заасан бол тэрийг нь төсөвт суулгах заавал суулгаарай гэсэн ийм чиглэл өгсөн тогтоол гарах юм шиг байна. Санал оруулж ирж байна. Тэгэхээр энэ дээр аялал жуулчлалын замууд гээд замууд байна л даа. Тэгэхээр тэр замууд дотор Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Сүхбаатар аймагт очоод амласан Баруун-Урт Сүхбаатар сумын чиглэлийн 61км зам байгаа юм. Энэ зам бол Буйр нуур луу тавигдаж байгаа засмал зам юм. Энэ зам баригдчих юм бол Монгол Улаанбаатараас Буйр нуур луу явахад ер нь цаана нь 100-гаад километр л үлдэх юм. Ингээд бүрэн авто засмал замаар нөгөө тосны зам нь холбогдох байхгүй юу. Ингээд явах ийм боломжоор хангана. Энийг бас Монгол Улсын Ерөнхий сайд тухайн үед зөв байна гээд, ард иргэдийн саналыг аваад, тэргүүлэх 5 ажлыг нь нэгд нь жагсааж байгаад Сүхбаатар аймгийн ард иргэдийн өмнө амласан байгаа. Энэ зам орж ирээгүй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны хуралдааныг 11 цаг хүртэл завсарлууллаа. Ажлын хэсэг байж байгаарай. Үндсэн хууль хэлэлцэж байгаа хэлэлцэнэ. Чуулганаа эхлүүлчхээд буцаж орж ирье. Ажлын хэсэг хүлээж байна шүү.

Нэгдсэн хуралдаан хуралдах болсон тул хуралдаан 10 цаг 12 минутаас 11 цаг 47 минутад түр завсарлав.

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хорооны завсарлага дууссан тул хурлыг эхлүүлье. Оюунчимэг гишүүн асуулт асууя. Оюунчимэг гишүүний микрофоныг нээе.

М.Оюунчимэг: Энэ 2020 оны 2024 оны хөгжлийн бодлогын нэг гол чиглэл нь

өөрөө хүний хөгжлийн асуудал гээд бүүр онцгой тавьсан байна л даа. Тэгээд түүн дээр нь аваад үзэхэд 1 дүгээрт гэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийг онцгойлон анхаарч арга хэмжээ авна гээд тэгсэн байна л даа. Одоо нийгмийн эрүүл мэнд гэдгийг тэр аваад үзэхэд хавдрын өвчлөл, гэдэс бохир, нян гээд агаарын амьсгалын замын өвчин гээд бүх өвчний үндэс нь өнөөдөр юунд вэ гэхээр агаар, хөрсний бохирдол байна л даа. Сая энэ 2022 онд БОАЖЯ байх дээр сансраас авсан зургаар нийслэл Улаанбаатар хотод гэхэд 144 мянган нүхэн жорлон байна. Ядахдаа эхний ээлжид нэг 1500-аас 2000 нүхэн жорлонг нь бүүр яаралтай арга хэмжээ авч байхгүй болгохгүй бол энэ нянгийн бохирдлоо бол бүүр энэ нийслэл Улаанбаатар хотын хүн амын дийлэнхийг өвчлөлд хүргэх нь гэнэ. Яагаад гэвэл нөгөө гүний ус худаг гүний усны хөрс нь шингээд ундны ус худагтаа ингэж бараг хүрч байна гээд энэ нь өөрөө сая илэрсэн байна шүү дээ. Маш нян Е-коли гэлүү тийм нян илэрлээ гээд. Энэ нян чинь өөрөө маш хортой бодис гэж байгаа байхгүй юу. Тэгээд хатуулагтай гээд тийм энэ жорлонгоос л гарч байгаа нян байхгүй юу тэр. Тэгээд ийм зүйлүүд илрээд байхад эндээс харахад бид хөрсний бохирдлыг бууруулах дээр тодорхой арга хэмжээ авна гэдэг чинь л өөрөө нөгөө нийгмийн эрүүл мэндийн асуудал өөрөө чухал байгаа шүү дээ.

Агаарын бохирдлыг харахад нөгөө ядахдаа коксжих нүүрсний түлшнийхээ үйлдвэрийг барьчихна гэсэн. Энэ 2022, 24 оны төлөвлөгөө дээр энэ нь яаж туссан юм бэ? Хөрсний бохирдлыг бууруулах дээр БОАЖЯ бас энэ нүхэн жорлонгуудыг халах ажлыг эхлүүлсэн ч дутуу орхиод хаячихсан ийм байгаад байна. Тэгэхээр та нар маань энэ 2024 онд хөрсний бохирдлыг бууруулах дээр яг хэдий хэмжээний санхүүжилт тусгаж, хэчнээн энэ хөрсний бохирдлын тэдэн хувийг нь бид шийднэ гэсэн ийм зүйл дээр надад нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэх байна.

2 дахь зүйл нь би өчигдөр Герман Монголын эдийн засгийн форум буюу

бизнес эрхлэгчидтэй ингээд уулзлаа л даа. Уулзсан чинь БОАЖЯ-ны аялал жуулчлал хариуцсан Мөнхбат гэлүү нэг л даргатай нь уулзсан юм шиг байгаа юм. Тэгээд танайх Аялал жуулчлалын хуулиа гаргаад аялал жуулчлалыг энэ 2024, 25, 26 онуудад тэргүүлэх чиглэл гээд ач холбогдол өгч байгаа гэсэн. Энэ дээр ямар бодлого барьж байгаа юм, бид яаж хамтарч ажиллах вэ, ямар хөрөнгө оруулалтыг дэмжих вэ гэх мэт асуухад тэр хүн нь ингэсэн гэж байгаа юм. Бид Азийн чиглэлд л онцгойлон анхаарч байгаа. Азийн чиглэл манай гол, Европ бол бас одоохондоо нэг их тодорхойгүй гэж бараг хэлсэн юм шиг байгаа юм. Нөгөө Германы аялал жуулчлалын хөрөнгө оруулагч гайхаад танайх чинь аялал жуулчлалын хүрээнд зүгээр Азидаа л анхаарч, Ази руу л чиглэх юм гэсэн ойлголт би авсан гэж байгаа юм.

Яаж тэгээд ийм бүхэл бүтэн Европын холбооны гол улсын аялал жуулчлалын компани нь энд хөрөнгө оруулалт хийх, манай хууль дүрмийг сонирхож байхад салбарын хүмүүст нь иймэрхүү нэг мэдээлэл өгөөд байж байж болох уу? Бид нар чинь аялал жуулчлалыг бүхий л чиглэлд хөгжүүлэе. Тэр Ази руу чиглэсэн, Европ руу, Америк руу гээд л бүгд бодлогоо гаргаад, Европ руу бид ийм бодлого барьж байгаа ийм, ийм нислэг Франкфурт, Турк ч гэдэг юм уу, Москва ингэж ниснэ, энэ чиглэлээр бид ийм хөрөнгө оруулалтыг ингэж татна гэж ярихын оронд ийм нэг тийм буруу ч гэх юм уу, дутуу ч юм уу мэдээлэл энэ тэр өгөөд байж байна л даа. Тэгээд яаж ингэж хоорондоо уялдаа холбоотой байх юм. Тэгээд энэ аялал жуулчлалын бодлого дээр чинь Европ руу чиглэсэн, Ази руу чиглэсэн энэ бодлогуудыг яг та нар тусгайлан 2024 онд тэдэн хувь дээр нь бид ийм, ийм онцгойлон анхаарна гэж тооцоолсон зүйл байна уу? Ийм нэгдсэн ойлголттой, бодитой мэдээлэлтэй байхгүй бол энэ юм чинь нэгд явахгүй байна гэдгийг хэлэе. Энэ миний 2 дахь асуулт шүү.

3 дахь асуулт нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас асуухаар

энэ сая Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд энэ соёлын салбарынхны цалин хөлсийг эрүүл мэнд, боловсролын салбартай нь адилтгаж тэгшитгэнэ гэсэн утгатай мэдээлэл өгчих юм. Яаж ингэж салбарынхныг цалин хөлсийг тэгшитгэнэ гэж би л энийг ойлгохгүй байна л даа. Ялгааг арилгана гэж хэлж байгаа юм уу эсвэл одоо.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт эхлээд Байгаль орчны яам 5 номер дээр, 5 номерын микрофон нээе.

С.Цэрэндулам: БОАЖЯ-наас Уур амьсгалын өөрчлөлт болоод төлөвлөлтийн газрын дарга Цэрэндулам хүрэлцэн ирсэн байна. Тэгээд гишүүний асуултад хариулъя. Орчны бохирдлыг бууруулах нэн ялангуяа нүхэн жорлонгийн асуудлыг шийдвэрлэх асуудал дээр бол зөвхөн манай яамнаас хамааралтайгаас гадна БХБЯ, НЗДТГ орон нутгийн юу гэдэг юм байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт бол маш чухал байдаг. Нэн ялангуяа энэ жилийн хувьд бол Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хүрээнд бол 1 тэрбум төгрөгийг бол төсөвлөөд түүгээрээ дамжуулагдаад нийтдээ 1 мянга орчим жорлонг бол одоогийн байдлаар юу гэдэг юм эхлүүлчихсэн ингээд явж байгаа. Гүйцэтгэл 98 хувьтай явж байна гэсэн ийм мэдээлэлтэй бол байж байгаа.

Нөгөөтээгүүр бол улсын төсвийн хөрөнгөөр бол нүхэн жорлонг юу гэдэг юм сайжруулах, дахин төлөвлөх ийм боломж бололцоо бол байхгүй гэдэг ийм чиглэлийг бол Улсын Их Хурлаас өгсөнтэй холбогдуулаад АХБ-ны тодорхой санхүүжилтийн механизмыг бол юу гэдэг юм үр дүнтэй ашиглах ийм зохицуулалтаар 2024-өөс 2026 онд бол нүхэн жорлонгийн асуудлыг шийдвэрлэнэ гэсэн ийм чиглэл гаргаад бол ажиллаж байгаа гэдэг тэр мэдээллийг бол танд өгье. Нарийвчилсан илүү мэдээллийг бол бас бичгээр өгөх боломж бололцоо бол байгаа байх гэж ингэж найдаж байна.

2 дугаарт нь аялал жуулчлалын бодлого чиглэлтэй холбоотой асуудал дээр бол манай яамнаас маш их олон бодлого чиглэлийн тэгээд л юу гэдэг юм хууль, эрх зүйн орчны гээд. Европтой холбоотой асуудал дээр бол манайх аялал жуулчлалын асуудал дээр нэгдсэн юу гэдэг юм стратеги бодлогыг гаргаад ингээд ажиллаж байгаа. ЗГ-ын хуралд бас танилцуулчихсан явж байгаа. Европын улсын орнуудын хувьд гэхэд энэ жилийн хувьд Германд ч гэдэг юм уу, тодорхой улс орнууд дээр бүүр ингээд аялал жуулчлалын экспо үзэсгэлэн яармагуудыг хүртэл зохион байгуулаад ингээд ажиллаж байна. Аль болох юу гэдэг юм 1 сая жуулчныг энэ жилдээ бол багтаан авах энэ юу гэдэг юм нэг талаасаа бол тооны, нөгөө талаасаа илүү эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх энэ ажил дээр бол бид нар хийж болох бүхий л ажлуудаа хийгээд явж байгаа гэж ингэж ойлгож бол ажиллаж байгаа. Тэгээд магадгүй тухайн хүмүүсийн ойлголт мэдээлэл хоорондоо зөрүүтэй дутуу ч байдаг юм уу, иймэрхүү зүйлүүд гарч ирсэн байхыг үгүйсгэхгүй юм. Яг юуны талаар бас яриад, юуны талаар юу гэдэг юм хоорондоо бас санал зөрүүтэй ийм ойлголт гарсныг бол сайн хэлж мэдэхгүй байна. Цэрэндулам.

Ж.Бат-Эрдэнэ: Асуулт хангалттай юу? Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 5 дугаар микрофон дээр, ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе.

Х.Хишигбаяр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлаар бол ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Яг энэ дээр бол бид нар бол гол нь эрүүл мэнд, соёл, биеийн тамир, спорт, шинжлэх ухаан, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хэт зөрүүтэй байгааг л бид нар ямар ч байсан

ойртуулъя гэдэг ийм байдлаар бол тооцоо судалгаа хийгээд явж байгаа.

Монгол Улсыг хөгжүүлэх 24 оны төлөвлөгөө дээр бол бид нар бас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлнэ гэсэн арга хэмжээг бол оруулаад явж байгаа. Энэ дээр бол бид нар урьдчилсан тооцоо хийгээд 20 хувиар албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх юм бол 700 гаруй тэрбум төгрөг шаардлагатай гэдэг ийм тооцоо судалгаа хийгээд явж байгаа. Одоо ажлын хэсгийн хүрээнд бол бид нар цалингийн зөрүүнүүдийг ойртуулах, дээр нь тэтгэвэр цалинг нэмэгдүүлэхэд бол бас үе шаттай нэмэгдүүлэхэд хэчнээн төгрөгийн зардал орох юм бэ гэдэг дээр бол бас тооцоо судалгаа хийгээд ингээд ажиллаж байгаа. Тэгээд яг бол эцэслээд бол яг соёлын салбарыг тийм болгоно бусад төрийн албан хаагчийнх тийм болгоно гэдэг дээр бол яг эцэслэсэн зүйл байхгүй. Шат шатлалаар тооцоолол хийгээд л ажиллаад л ажлын хэсэг ажиллаад явж байна одоо бол. Төсвийн тодотголоор бол тодорхой шийдэл гарах юм бол бид нар одоо бол төсвийн тодотголд оруулахын тулд хувилбаруудаа бол хийгээд ажлын хэсэг дээрээ ажиллаад явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Оюунчимэг гишүүн тодруулъя. Оюунчимэг гишүүний микрофон.

М.Оюунчимэг: Цэрэнчулуун дарга маш тодорхой хариулмаар байна. Ажлаа аваад хэр удаж байгаа юм бол доо. Жишээ нь сая миний хэлж байгаа дээр 1 тэрбум биш 4 тэрбум төгрөгөөр яг энэ Улаанбаатар хотын гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах нүхэн жорлонг халах, тэр хөрсний асуудлуудыг лагийг нь эргээж цэвэршүүлэх гэх мэт ажлыг эхлүүлж байгаад, 4 тэрбумын 1 тэрбумыг нь хийгээд дууссан гэсэн мэдээллийг жишээ танай сайд өгсөн. Сая өөрөө болохоор 1 тэрбум л ажил 90 хувьтай байгаа гэж байгаа юм. Яг 1 тэрбум 90 хувь гэдэг нь хаана хийгдсэн яг ажил байна вэ, дууссан уу? Тэгээд 4

тэрбум төсөвлөсөн. 3 тэрбум нь тэгвэл хаачсан гэсэн үг юм бэ? Энэ 2024 он руу орж байгаа юм уу 1 дүгээрт.

2-т нь аялал жуулчлалын тал дээр та нар маань нэгдсэн бодлого алга. Өөрийн чинь ярианд ч ойлголт алга. Нэг ерөнхий юм өгч байна. Тэгээд сүүлийн үед ер нь нэг бичгээр хариу өгчхөж болох байх гэдгийн Улсын Их Хурлын чуулган дээр, Байнгын хороон дээр эрхэм гишүүд асуулт асуувал та нар хариулаад, би нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол надад бичгээр энийг өгвөл зүгээр байна гэж хэлж болно биз. Та нар энэ дээр ингээж хэлчхээд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Хариулт 5 номер дээр, 5 номерыг ажлын хэсгийн 5 номерыг.

С.Цэрэндулам: 1000 нүхэн жорлонгийн юу гэдэг юм дахин шинэчлэх, төлөвлөх, хийж хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг бол Орхон аймаг дээр хийж гүйцэтгэсэн байгаа. Нийт гүйцэтгэл 98 хувьтай байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. 3 тэрбумтай холбоотой асуудлыг бол БХБЯ яамнаас бол мэдээлэл өгөх байх гэж бодож байна. Яагаад вэ гэхээр зэрэг БХБЯ бас тодорхой хэмжээгээр энэ асуудал дээр ажил хийгээд ингээд явж байгаа гэсэн ийм бид бол ийм ойлголттой байгаа. Бас мөн нийслэл мэдээлэл өгөх байх гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Би Эдийн засгийн байнгын хороонд байдаггүй. Гэхдээ бас санал зарчмын зөрүүтэй санал хэлэх гэсэн юм. Асуудал юу байгаа гэхээр манай БЗД-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нэлээн хоцрогдчихсон, улсын чанартай эмнэлэг байхгүй болчихсон. Улсын эмнэлэг байсныг нь хувьчлах нэрийдлээр 90-ээд оны үед ингээд аваад, одоо 400 гаруй мянган иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ ерөөсөө байхгүй. Тэгээд энэ зарчмын зөрүүтэй санал БЗД-ийн

эмнэлгийн жагсаалтад энэ тогтоолын төсөлд оруулах ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Нийт өртөг нь бол 25 тэрбум төгрөг. Тэгээд 1 жил дотроо шууд ашиглалтад орох ийм боломжтой судалгаа бүх юмыг нь хийчихсэн.

Ер нь бол энэ АХБ-ны санхүүжилтээр нэг том дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлэг барихад 60 сая доллар зарцуулж байгаа юм, 60 сая доллар. Тэгвэл манай энэ БЗД-ийн эрүүл мэндийн газраас судалж үзээд гаргаад яг ийм хэмжээний эмнэлэг барих зардлаа 25 тэрбум буюу маш бага зардлаар тэгээд маш шуурхай хийх ийм боломжтой судалгааг хийчихсэн, эдийн засгийн судалгаа хийчихсэн. Цаашид засвар үйлчилгээг нь яаж хийх вэ, яаж авч явах вэ энэ тэр гээд бүх судалгаа хийчихсэн ийм байгаа юм. Тийм учраас Бат-Эрдэнэ гишүүнээс бүүр зориудаар энэ зарчмын зөрүүтэй санал дээр санал хураалгаж өгнө үү гэж танаас хүсэх гэж зориуд үг авсан юм.

Ж.Бат-Эрдэнэ: Та бичгээр саналаа өгчихсөн байгаа тийм ээ? Санал хураалтад оруулчихна. Ганбаатар гишүүн, С.Ганбаатар гишүүн асуулт асууж, санал хэлье гэж байна.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын Монгол Улсын 2021-2025 оны хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, та нар нэг хараадах. 5.1.3, 5.1.4-д Монгол Улсын ЗГ-ын 2020, 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 20 оны 24 дүгээр тогтоолын 4.2.10-д, 4.2.10-д заасан зорилтуудыг нь биелүүлэх талаар Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд яагаад хасагдав? Яагаад энэ байхгүй байна вэ? Энэ хамгийн чухал асуудал шүү. Энэ дээр байхгүй байгаад байгаа байхгүй юу.

Энэ чинь бол яг нарийн яривал Улсын Их Хурлын тогтоолын энэ төсөл би та нарт яг уншиж өгөх юм бол 5.1.4

дээр 5.1.3 дээр ингэсэн байгаа юм. Нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа засаглалын бүх шатад олон талт түншлэлийг оновчтой үр дүнтэй нэвтрүүлнэ гэж байгаа юм. Манай оронд хамгийн чухал юм энэ байгаа шүү дээ. Нийгэмд олон талт түншлэлийг. Ерөөсөө л Засгийн газар би бүхнийг мэднэ гээд л ганцаараа орилоод байдаг, амьжиргаа унаад л байдаг. Бизнес эрхлэгчид болон тэр хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн төлөөллүүдийг шийдвэр гаргах явцаа оролцуулъя л гэдэг нь хамгийн чухал зорилт шүү дээ энэ чинь. Энэ чинь дэлхий нийтээрээ ярьж байгаа зүйл.

5.1.4.Хорин нэгдүгээр зууны төрийн удирдлагын шинэ арга барил болох 3 талт хөгжлийн онолын дагуу улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа засаглалын бүх шатад 3 талт түншлэлийг оновчтой үр дүнтэй нэвтрүүлнэ гэж байгаа юм. Үгүй ээ энэгүйгээр та нар зүгээр дураараа улсыг удирдана гэж, дарга удирдана гэж байхгүй шүү дээ. Бизнесменүүдтэй ард түмэнтэйгээ хамтарч түншилж удирдана гэдэг энэ өөрөө 21 дүгээр зууны онол байхгүй юу даа.

4.2.10.Нийгмийн зөвшилцөлд зөвшилд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатад төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх гэж байгаа шүү дээ. Та нар зүгээр зөвлөлдөх, шийдвэр гаргахдаа энэ татвар авахдаа тэр татвар өгөх гэж байгаа компанийн эздийн төлөөллийн байгууллагатай зөвлөлдөнө л гэсэн үг. Энэ оновчтой тогтолцоог бүрдүүлнэ гэсэн үгүй ээ мөн гоё юмыг байхгүй болчихож. Ядаж ор нэр төдий байлга л даа энэ дээр. Яагаад хасчихсан юм бол? Би 1 дүгээр асуулт энэ. Дараа нь хариулсных нь дараа би хариулт авна.

2 дугаар асуулт. Шар хөтөлийн зам гээд энэ манай Эрдэнэттэй холбоотой юм байгаа юм. Энэ их чухал юм байгаа юм. Эрдэнэттэй манай Орхон аймагтай холбоотой туссан саналуудад

ингээд харах юм бол 2.2.3.1 зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах гэж байна. Эрдэнэтийн үйлдвэрийн төрийн өмчит уул уурхайн металлургийн хөгжлийн үйлдвэрлэлийн цогцолбор гэж байгаа. Энэ болгоныг яг хэрэгжүүлэх амин судас нь дэд бүтцийг нь байгуулах ёстой. Шар хөтөлийн зам энэ дээр баталгаатай орж байгаа юу? Ямар шатдаа явж байгаа вэ? Яг энэ ард иргэдийн зовлон зүдгүүр Засаг дарга байсан манай Батлут гишүүн энүүгээр маш их санаачилгатай явж байгаа. Энэ ажил маань орсон гэдэгт би итгэлтэй байна. Энүүгээр би дэлгэрэнгүй хариулт авъя. Хариултаа авсны дараа би хоёуланд нь би бас нэг нэмж хэлэх зүйлүүд байгаа. Алсын хараа 2050-д ч гэсэн энэ дээр тусчихсан байгаа зүйлүүд та нарын оруулж ирж байгаа энэ хөгжлийн төлөвлөгөө дотор хасагдчихсан байна, яагаад вэ?

Ж.Бат-Эрдэнэ: 4 номероос ажлын хэсгийн 4 номер.

Л.Балчинлувсан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлувсан. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу ялангуяа 6.10.2, 6.10.1 болон 4.1.13-д заасны дагуу тусгай тийм шаардлагууд хуулийн шаардлагууд байгаа. Энд юу гэж байгаа вэ гэхээр Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв санхүүгийн эх үүсвэрийг тусгасан ажил, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн бичиг баримтыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө гэнэ гэж байгаа.

Тэгэхээр энэ жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа бид нар өмнөх жилүүдээс ер нь сайн сайжруулж Алсын хараа урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого болон бусад бодлогуудын бичиг баримттай уялдсан байдлыг бол маш чухалчилж авч

хэрэгжүүлсэн байгаа. Одоо энэ статистик бид нар төсөөлөл гаргасан байгаа. Бодлогын бичиг баримтууд хэлэхэд сая сая таны хэлсэн шиг Алсын хараа, Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр бусад бодлогын бичиг баримтад баримтуудтай 100 хувь уялдсан 2024 оны жилийн төлөвлөгөө.

Тэргүүлэх чиглэлүүдээр таны хэлсэн гол асуудлууд нь тэр засаглалыг сайжруулна, засаглалын үзүүлэлтүүдийг сайжруулна гэдэг 7 дугаар тэргүүлэх чиглэл дээр. Энийг цаашаа дэлгэрүүлж үзвэл энэ засаглалын үзүүлэлт гэдэг дотор таны ярьж байгаа бүх заалтууд ордог. Тэгэхээр энэ жилийн жилийн төлөвлөгөөний онцлог нь юу юм бэ гэхээр өмнөх жилийн төлөвлөгөөнүүдээсээ онцлог нь үр дүнд суурилсан байдлаар 3 хавсралттайгаар төсөл боловсруулсан байгаа юм. 1 дүгээр хавсралт нь болохоор тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж өгсөн, бодлогын чиглэлүүдийг. 2 дугаар хавсралт дээрээ тэр тэргүүлэх чиглэлүүдийн бодлогуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөл, арга хэмжээг түсгэж өгсөн. 3 дугаар хавсралтыг нь та сайн анхаарвал шалгуур үзүүлэлтүүд энэ бодлогын үр дүнгүүдэд хүрэхэд ямар шалгуур үзүүлэлт үр дүнд хүрэх ёстой вэ гэдгийг заах зааж өгсөн байгаа.

Тэгэхээр засаглалын үзүүлэлт сайжруулна гэдэг дээр таны дурдсан бүх үзүүлэлтүүд ордог учраас энэ шалгуур үзүүлэлтүүд энэ 3 хавсралтууд хамтдаа нэг цогц бодлогын бичиг баримт болж авна.

Ж.Бат-Эрдэнэ: 7 дугаар микрофон, ажлын хэсгийн 7 дугаар микрофон Зам, тээврийн хөгжлийн Төрийн нарийн бичгийн дарга.

С.Батболд: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Зам, тээвэр хөгжлийн яамны ТНБД Батболд. Шар хөтөлийн замын зураг хийгдээд дууссан. Азийн юу Европын сэргээн босголт хөгжлийн банктэй энэ талаар санхүүжилт авч

ажиллахаар явж байгаа. Саяхан Сангийн яам манайх Азийн юу Европын сэргээн босголт банк хамтраад энэ нөгөө зээл олгохтой холбоотой урьдчилсан судалгааны ажлыг энэ онд эхлүүлээд дуусгахаар ийм гэрээ байгуулсан байж байгаа. Энэ 24 оны энэ үндсэн чиглэлд бол энэ асуудал ороогүй байгаа. Банк бол ер нь тавьсан саналын дагуу эхний шалгуур давсан, тэрний дараагийн судалгаагаа хийе гэдэг байдлаар одоо явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: С.Ганбаатар гишүүн тодруулъя, С.Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Манай залуу дарга юмаа сайн уншихгүй бол 7.4-д нэг төрийн үйлчилгээг авах, хүртэх зардлыг бууруулах, хувийн хэвшлийн бүтээмжийг дэмжих бодлогын оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн сан гээд явчихсан байна. 7.5 нь төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын засаглал үр өгөөжийг сайжруулж, олон улс гээд ингээд явчихсан байна. Олон улсын чанарын стандарт. Та нар сэтгэлгээгээ жоохон өөрчилмөөр байгаа юм даа яана аа, ингэвэл улс орон хэцүү байна шүү дээ энэ чинь. Та нар сэлүүр биш, залуур байгаарай л гэж байгаа юм шүү дээ.

Өөрөөр хэлбэл нэг би чадна, би энэ компаниудыг босгочихно гээд л дарга нар дайраад ороод байх юм. Хамгийн гол нь өнөөдөр энэ ажлын байр бий болгоход яг энэ юмны үнийг бууруулахад, амьжиргааг дээшлүүлэхэд би чадна гээд Засгийн газар орох биш, надаас илүү хэн чадах вэ гэдгийг нь ярих гээд байгаа шүү дээ. Миний ярих гээд байгаа зүйл гэвэл түншлэлийн механизм, хамтын зөвшилцөл.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудын санал хураалтыг эхлүүлье. Болно. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн 2.2, 2, 3, 4 дүгээр зүйл, заалтыг 2 дугаар заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр хангаж, Улсын Их Хуралд танилцуулах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Доржханд, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, С.Чинзориг цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Уучлаарай төхөөрөмж ажилласангүй. Саналыг хүчингүйд тооцоод дахин санал хурааж өгнө үү. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалтыг хүчингүйд тооцож санал хураалт эхлүүлье. Хүчингүйд тооцох санал хураалт. Санал хураалт. Санал хураалт 75 хувиар зөвшөөрөгдлөө. Энэ чинь санал хүчингүй боллоо 75 хувиар санал хүчингүй боллоо. Санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүнээс 9 гишүүн оролцож 75 хувиар дэмжлээ.

2.Тогтоолын төсөл доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай. Санал хураалт. Санал хураалтад 12-оос 7 гишүүн оролцож 58,3 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “төлөвлөж хэрэгжүүлэх,” гэсний дараа “нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах,” гэж нэмж, мөн зүйлийн “мөнгөний бодлогын тохируулгыг оновчтой хийх,” гэснийг “мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах,” гэж өөрчлөх. 4 энэ тусдаа явах юм уу, энэ энд орчихсон байсан, тийм үү? 72.7 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.” гэсэн агуулгатай 2.3 дахь заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Жоохон гүрийлгээ. Санал хураалтад 8 гишүүн оролцож 72.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. 5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.” гэсэн агуулгатай 8.1.5 дахь дэд заалт нэмэх. Санал санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 72,7 хувиар дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1.1 дэх заалтын “Агаарын геофизикийн 1:2000-ны масштабын судалгааны ажлыг

гүйцэтгэх” гэснийг “Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх” гэж, мөн шалгуур үзүүлэлтийн “Талбай хамралтад” гэснийг “Нислэгт хамрагдсан талбай” гэж, үр дүнгийн үзүүлэлтийн суурь түвшин “66” гэснийг “0” гэж, хүрэх түвшин “100” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 81,8 хувиар дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.1 дэх заалтын “Зэсийн” гэснийг “Зэс, алт, мөнгөний” гэж өөрчилж, мөн заалтад Төсөл, арга хэмжээнд “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Зорилтот түвшинд “100” гэж, Хариуцагч байгууллагад “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” гэсэн 2.2.2.2 дахь дэд заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг зогсооё, асуулт. Энэ чинь асуулт байгаа билүү? Зүгээр санал хэлэх билүү? Санал хэлнэ дээ. Тийм. Санал хэлнэ. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Уул уурхай, эрчим хүч, Уул уурхайн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хоёулаа сууж байна. Мэдээж нөгөө нэг аль болохоор хөрөнгө оруулалт татаж, томоохон ордуудыг ашиглалтад оруулах асуудал бол чухал байгаа. Харин энд төсөл, арга хэмжээнд энэ Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордын ашиглалтад оруулах төсөл бэлтгэл ажил хангах гэж энэ Асгатын мөнгөний орд дээр нөгөө бас гаднын хөрөнгө оруулалттай холбоотой маргаан энэ тэр гараад л, янз янзын бас асуудал үүсээд байсан л даа. Тэгэхээр яг одоо гадаадын хөрөнгө оруулалттай хамтарч хийх гэж байгаа юм уу эсвэл хуучин хайгуулын ажил бас хийгдэж байсан. Гэхдээ бас орон нутгийн иргэдийн шүүмжлэл асуудалтай тулгараад энэ Асгатын мөнгөний ордыг ашиглахтай

холбоотой асуудал зогсчихсон байсан. Тэгээд Хармагтайн зэс, алтны ордны асуудал ч гэсэн нэлээд тийм хардлага дагуулаад байсан л даа.

Тэгэхээр одоо энэ асуудлууд ер нь урагшаа хөдлөхөд бэлэн болчихсон гэсэн үг үү? Эдийн засаг, ТЭЗҮ, судалгаануудыг нь гаргасан байгаа юм уу, эсвэл бүүр эхнээс нь эхлэх гэж байгаа юм уу? Хайгуул, лицензтэй холбоотой асуудлууд дээр нь хүртэл асуудалтай байсан шүү дээ. Тэгэхээр Ганбаатар сайд яг түүн дээр бас тодорхой мэдээлэл өгөх үү? Энэ уул уурхай, одоо яг хувийн эзэмшил дээр бас хөрөнгө оруулалтаа хувьцаа эзэмшдэг энэ тэр компаниуд байгаа юу эсвэл энийг яг төр өөрийнхөө мэдэлд аваад ер нь энэ хайгуулын ажлуудыг явуулчихъя гэж тооцоолж оруулж ирж байгаа юм уу? Энэ бол бас нэлээд анхаарал татаж байгаа 2 том ордны тухай асуудал яригдаж байна л даа. Энд хариулт авъя гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт зөвхөн тайлбар хэлнэ шүү дээ. Юу Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Асгат болоод Оюунчимэг гишүүнээ Асгат болоод Хармагтайн орд бол төрийн Эрдэс Монголын харьяанд бол байгаа. Тэгэхээр Асгатын хувьд бол ямар бодлого барьж байна гэхээр нөөцийг нь нэмэгдүүлж, олон улсын хөрөнгө оруулалтуудыг татах. Бид нарын бүүр 97 онд тэр нөөц нь тэр батлагдсан нөөцөөрөө байдаг. Тэгэхээр яг тэр нөөцөөрөө бол гаднын хөрөнгө оруулалтууд бас сонирхох хэмжээ нь бага байгаа юм. Тэгэхээр бид нар Эрдэс Монгол компани энэ саналыг гаргаж байгаа юм. Эрдэс Монгол гэдэг нь та мэдэж байгаа. Эрдэс Монгол компани тодорхой хөрөнгө гаргаад, хайгуулын ажлыг нэмэгдүүлээд, нөөцөө нэмэгдүүлэх юм бол гаднын болоод дотоодын хөрөнгө оруулалтууд Асгат дээр бол маш их олон сонирхол байгаа. Тэгээд гол шалтгаан нь өөрөө энэ гэдгийг хэлье.

Хармагтайн ордын хувьд ч гэсэн бас тэр технологийн хувьд бас нэлээн тийм шинэлэг технологиудыг ашиглах ёстой. Тийм ч учраас энэ тал дээр бас тэр технологи болоод хайгуулын талд нь хөрөнгө оруулалтуудыг Эрдэс Монгол компани өөрийнхөө нөөц бололцоогоор явна гэсэн ийм зүйлтэй байгаа юм. Мэдээж юу нь нөөц нь нэмэгдчих юм бол үргэлжлүүлээд хайгуулын ажлуудыг бол хувийн хэвшилээр болоод гаднын хөрөнгө оруулалтаар хийлгүүлэх боломжтой. Зүгээр эхний ээлжид нөөцөө нэмэгдүүлэх гэж байгаа юм гэдэг энэ, энэ томьёоллоор явж байгаа шүү гэдгийг л. Эрдэнэс Монгол компани ер нь өөрсдөө ишидвэрлээд явчих байх гэсэн ийм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал 81,8 хувиар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.4 дэх дэд заалтын хариуцагч байгууллагад Боловсрол, соёл, шинжлэх ухаан энэ чинь юу билээ, БШ гэгчихсэн байна. “БШУЯ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Үсгээр нь дурдах ёстой юм. Санал 90,9 хувиар дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээний “парк” гэснийг “паркийн дэд бүтцийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.9 дэх дэд заалтын Зорилтот түвшиний “80” гэснийг “60” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн 2 дугаар асуултын 2.3.2.5 дахь дэд заалтын Зорилтот түвшиний “50” гэснийг “100” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 90,9 хувиар дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн төсөл” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “20” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “2500” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 81,8 хувиар дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд Үр дүнд суурилсан өөрчлөлт өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн Шинжлэх ухаан, технологийн /суурь, шинжилгээний технологи/ судалгаа, хөгжүүлэлтийн ажил” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “350” гэж, Зорилтот түвшинд “450” гэж, Санхүүжилтэд “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 90,9 хувиар дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3, 4.3.1.7 дахь дэд заалтын Санхүүжилтэд 62493, 62 сая юм байна тийм ээ, 62 сая 493 мянга биш ээ, 62 мянга юм байна шүү дээ. 62493 зууны 82 гэснийг “19,388.4” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 81,8 хувиар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1.2 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн санал бас байна. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтын Шалгуур

үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь онд “2022” гэж, Суурь түвшинд “0.13” гэж, Зорилтот түвшинд “0.2” гэж, Мэдээллийн эх үүсвэрийг “ҮСХ” гэж, Мэдээллийн цуглуулах арга зүйд, Мэдээлэл цуглуулах арга зүйд “Статистикийн мэдээ” гэж, Мэдээлэл цуглуулах давтамжид “Жилд нэг удаа” гэж, Хариуцах байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 81,8 хавиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Бодлогын үндэслэл” гэснийг үндэслэл хэсгийн Алсын хараа /АХ/, 2.3.2.16 дахь дэд заалтын “3.2.14” гэснийг “6.4.22” гэж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /МУХТЖҮЧ/-ийн 2.1.3 дахь заалтын “4.2.2” гэснийг “4.4.3” гэж, мөн 3.1.4.1-3.1.4.5, 3.1.4.7, 3.1.4.8, 3.1.5.1 дэх дэд заалтын “2.1.9” гэснийг “2.1.12” гэж, мөн 4.2.1.1 дэх дэд заалтын “3.6.4” гэснийг “4.2.10” гэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-ийн 6.2.3 дахь заалтын “4.3.9” гэснийг “3.5.7” гэж, мөн тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын “бүсүүд” гэснийг “бүсүүдийн” гэж, 2-ын 3.2 дахь заалтын Хэмжих нэгжийн “Хүн” гэснийг “Хувь” гэж, 3.3.2 дахь дэд заалтын шалгуур санхүүжилтийн “хамралт” гэснийг “хамрагдалт” гэж, 3.3.3 дахь дэд заалтын Зорилтот үр дүнгийн “нэмэгдэнэ” гэснийг “нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлтийн “насныхны” гэснийг “насны” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 90,9 хувиар дэмжигдлээ.

2.Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 90.9 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолуудаар санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2-т санал нэмэх. Саналын томьёолол Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21мвт-аар өөрчлөх санал нэмэх, төсөвт өртөг 16,7 тэрбум төгрөг, эх үүсвэр Улсын төсөв. Санал гаргасан Л.Мөнхбаатар. Санал хураалт. Яах юм тэгээд дэмжээд, дэмжээд. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

Х.Ганхуяг, Т.Энхтүвшин нарын санал. 1.Монгол Улсын хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн өгөх санал. 1.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.5-д 2023-2024 оны хичээлийн жилд 3 ээлжид орох нөхцөл үүссэн ерөнхий боловсролын сургуулийн шинээр баригдаж байгаа барилга байгууламжийг барина гэж шинээр нэмэх. Санхүүжилтийн энэ санхүүжилтийн эх үүсвэр заагаагүй юм байна. Санхүүжих дүн байхгүй юм байна. Тэгэхээр энэ уг нь санал хураалтад орохгүй дээ. Ганхуяг гишүүн, Энхтүвшин. Баттөмөр ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ бол байна шүү дээ. Энэ явж байгаа тэр үнийн дүнгүй зөндөө олон заалтууд байгаа шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр ерөнхий утгаар нь ингэж оруулаад, тэгээд явах нь бол дээр болов уу? Үнэгүй асуудлууд, үнэ тавиагүй маш их олон асуудлууд байгаа шүү дээ энэ дотор. Тийм ээ. Би тэгж бодож байна. Зүгээр яам ямархуу бодолтой байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ чинь үнийн дүнгүй, санхүүжилтийн эх үүсвэргүй юмыг чинь бид нар санал хураагаад наана чинь ажил болох уу? Энэ чинь зураг төсөвгүй гэсэн үг биз дээ? Хуулиараа бол

энэ чинь болохгүй байх ёстой тийм үү? Аудит дээр очоод наадах чинь унана л даа. Тэгээд батлагдаад явна, тэгээд хэрэгжилт дээр очоод хэрэгжихгүй л гэсэн үг. Асуудал нь бол бас юутай юм байна. 1 дүгээр хавсралтын тэргүүлэх чиглэл рүү оруулах юм уу? Хүрэлбаатар сайд. Байгаа юм уу? Энэ чинь одоо ерөөсөө ингэж байна шүү дээ. Хичээлийн жил 3 жил ээлж бол орох, уг нь бол асуудал байгаа тийм үү? Орох нөхцөл үүссэн ерөнхий боловсролын сургуулийн шинээр барьж байгаа барилга байгууламжийг барина гэж байна. Энд яг тэнд энд гэсэн хүн бол юм байхгүй юм байна тийм үү? Энэ зүгээр ерөнхий заалт орж ирж байна шүү дээ. Зөв үү? Энхтүвшин. Энхтүвшин гишүүн тайлбар хэлэх үү? Энхтүвшин гишүүнд.

Т.Энхтүвшин: Байгаа бол яах вэ.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн 4 номер. 4 дүгээр микрофон.

Л.Балчинлуvsан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлуvsан. Тогтоолын төслийн 3.1.4 дээр боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ гэсэн заалтын дагуу энэ бодлогын бичиг баримтад туссан байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ингэчихвэл, ингэвэл яасан юм бэ сайд? Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье. Ч.Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Ер нь энэ манай яаман дээр бас нэлээн яригдсан юм. Боловсролын яамныхан ч бас ирээд уулзсан. Тэгээд энэ 3 ээлжээр хичээллэдэг энийг бүүр цэг тавих ёстой энэ үлдсэн бүх ажлаа дуусга гэж яриад, тэгээд манайхан бодож, бодож байгаад ингээд л томъёолчихсон юм шиг байна. Яг энэ бол агуулгаар нь яаман дээр яригдаад, хийгдчихсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Бодлогын хүрээнд бол та дэмжиж байгаа, ойлгомжтой

тийм үү? Тэглэе гэж байгаа шүү дээ тийм ээ.

Ч.Хүрэлбаатар: Энийг ярьсан юм. Тийм, ерөөсөө 3 ээлжийн сургууль гэж байж болохгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Наад саяын уншсан заалтыг чинь яг ингэж ойлгох уу?

Ч.Хүрэлбаатар: Ойлгоно. Яг ойлгож төсөв дээрээ ингэж юмаа оруулна.

Ж.Бат-Эрдэнэ: Та бүхэн яг ингэж ойлгоно шүү.

Ч.Хүрэлбаатар: Дэлгэрэнгүй биччихэж болно.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл Энхтүвшин гишүүн саналаа татаж байна тийм үү?

Ч.Хүрэлбаатар: Ер нь тэглэнэ гэж, бүүр тэглэнэ гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүнд микрофон өгье.

Ч.Хүрэлбаатар: Орно, ерөөсөө 3 ээлжийн сургууль гэж ерөөсөө байхгүй болгоно л гэж ярьж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Яг ингэж ойлгоно шүү гэдгээ тодруулчих.

Т.Энхтүвшин: Ерөнхийд нь Хүрэлбаатар сайдын яриаг ойлголоо. Тэгээд 3 ээлжийн сургуульгүй болох юм байна, одоо хийгдэж байгаа хөрөнгө оруулалтууд гүйцээгдээд сургуулиудаа барьж дуусгах юм байна гэж ойлголоо.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл саналаа Энхтүвшин гишүүний микрофоныг өгье дөө.

Т.Энхтүвшин: Санхүүжилтийн асуудал ямар ч байсан шийдэгдэж байгаа, тэгээд ямар ч байсан энэ сургуулиуд баригдаж дуусах юм байна, хөрөнгө

оруулалтыг нь нэмж тавих юм байна гэж ойлгоод энэ заалтаа татаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн, Ганхуяг гишүүд саналаа татлаа шүү. Тэгэхээр саяын заасан уншсан заалт бол яг энэ утгаараа 3 ээлжийг байхгүй болгоно гэдгээр ойлгож хийгдэнэ гэж ойлгож байх шиг байна.

Ч.Хүрэлбаатар: Одоо ингээд эрэмбэлээд, боловсролын салбарын сургуультай холбоотой хөрөнгө оруулалтыг эрэмбэлээд бид нар яг дээрээс нь 3 ээлжийгээ эхлээд дуусгана. Тэгээд тэрэн дээр нь мөнгө үлдвэл дараагийн сургууль дээр, мөнгө үлдэхгүй бол.../үг тасрав/

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар сайд маань өөрөө тайлбар хэллээ. Яг ингэж ойлгоод явъя. Ойлголоо.

Дараагийн санал С.Ганбаатар гишүүний санал байна. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 5.1.3, 5.1.4 дэх заалтууд, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын 4.2.10 дахь заалтыг тус тус нэмэх. Ганбаатар гишүүн саналаа тайлбарлах уу? Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Энд ямар ч мөнгө төгрөгтэй холбоотой юм байхгүй. Санхүүжилттэй холбоотой юм байхгүй. Зөвхөн ойлголцол, зөвшилцлийн механизмаа энэ шинэ шатанд гаргая л гэж байгаа юм. Монгол оронд бол хөдөлмөрийн харилцаа бол 3 шат, 3 талт хэлэлцээр, 3 талт зөвшилцөл гэдгээр явдаг. Бусад оронд бол хөдөлмөрийн харилцаа зөвхөн нэг цалин тариф ярихаасаа илүү цаана нь маркетингийн зах зээлийн асуудал ярьдаг. Тэр олон тендер, төсвийн тэр бодлогууд бүгдээрээ тэр бизнес эрхлэгч нартай ярьдаг байя, зөвшилцдөг байя, зөвлөлддөг байя гэж байгаа юм.

2 дугаарт нь хүний нөөцийн бодлого. Төр тэртээ тэргүй оролцдог. Бүх их, дээд сургууль, энэ боловсролын бодлогууд бол хүний нөөц төр дээр бас оролцдог. Зөвшилцье, ойлголцъё.

3 дугаарт нь тавхан зүйл байгаа. Маш олон юм байхгүй. Татварын бодлого ярилцъя, зөвшилцье. Тэднийг үл ойшоогоод бид дандаа өөрсдөө их мэдэх царайлаад шийдээд байвал болохгүй гэж байгаа юм.

4 дүгээр бодлого. Тэр зээлийн бодлого, санхүүжилтийн бодлого, мөнгөний бодлого.

5 дугаар бодлого хамгийн чухал бодлого. Технологийн бодлого. Улс орон, Засгийн газрууд know how технологийг бизнесменүүдтэйгээ зөвлөлдөж оруулж ирдэг. Энэ 5 бодлого байж эдийн засаг босдог. Тэгээд энэ утгаараа энэ заалт нийгмийн үндсэн, түншилэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх санал авах гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ л гэдэг энэ гоё заалт байгаа. Энийг хэрэгжихгүй ч гэсэндээ ядаж оруулчихаач.

Хамгийн гол нь Эдийн засгийн яам өнөөдөр бусад яамнуудаа шахаж байх ёстой байхгүй юу. Бусад агентлаг, аймгийн Засаг дарга нар өөр юу байна вэ бусад бүх яамнууд дээр энэ хэрэгжих ёстой. Дарга гээд л өнөөдөр 50 метрийн цаана байгаа хүнээс бизнес эрхлэгчид иргэний нийгмийн байгууллага маш хөндий хол болчихсон. Хоорондоо ярилцах, зөвшилцөх, ойлголцох, гаргах гэж байгаа шийдвэрээ ярилцах явдал их чухал юм гэж би итгэж үнэмшиж байна. Тэгээд ямар нэгэн төсөвт мөнгө төгрөгийн дарамт байхгүй. Тэртээ тэргүй тэр бизнесменүүдээс хурааж авч байгаа мөнгөө буцаагаад яаж нийгэмд зөв зарцуулах вэ гэвэл тэр хурааж авсан хүмүүстэйгээ зөвлөлддөг механизм

байвал олон улсын *tendency* юм уу гэж би итгээд байгаа. Тэгээд энийг оруулна.

Залуу дарга маань түрүүн их чухал юм санаа хэлсэн л дээ. Зүгээр 7.4, 7.5 гээд яриад байх шиг байна. Төрийн болон гээд л шууд эхэлж байгаа юм. Төрийн үйлчилгээг авах, хүртэх, зардлыг бууруулах, хувийн хэвшлийн бүтээмжийг дэмжих, дэмжих гээд л одоо ерөөсөө л хамтарч ойлголцъё, зөвшилцье гэсэн санааг энд байна л даа. Энэ 20 онд оруулсан энэ гоё заалтыг хэрэгжилт дээр цөмөөрөө нэг хүч тавивал яадаг бол гэсэн ийм санал байна. Гишүүд маань мэргэн ухаандаа дэмжиж өгч туслаарай.

Ж.Бат-Эрдэнэ: С.Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 90 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын С.Чинзориг гишүүний зарчмын зөрүүтэй саналын томъёоллын. Саналын томъёолол. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.3.2.2 дахь дэд заалтын Улсын төсөв гэснийг Төр хувийн хэвшлийн түншил гэж, мөн хавсралтын 3.3.2.3 дахь дэд заалтын Төр хувийн хэвшлийн түншил гэснийг улсын төсөв гэж өөрчлөх. Санал хураалт. 90 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 4.3.1.Аялал жсуулчлалын авто замын сүлжээ нэмэгдүүлнэ гэж байна. Саналын томъёолол. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад 4.3.1.20 Улаанбаатар Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих, 20 хувь улсын, 20 хувь улсын төсөв улсын төсвөөс санхүүжих юм байна. Төсөвт өртөг нь 28 тэрбум, Зам, тээврийн хөгжлийн яам гэсэн заалтыг нэмэх гэж байна. Санхүүжилтийг нь 20 хувийн санхүүжилт явуулъя гэж байгаа юм байна тийм ээ, эхлүүлье гэж байгаа юм байна. Үргэлжлүүлж байгаа юм уу? Санал хураалт. 2 дахь заалт 4.3.1.21 Өвөрхангай

аймгийн Арвайхээр, Баянгол, Сайхан-Овоо, Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын техник эдийн засгийн ТЭЗҮ-ийн боловсруулах гэж байна шүү. Санхүүжилтийн санхүүжилт нь 4 тэрбум юм байгаа биз дээ? 4 тэрбум төгрөг. Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал Улсын төсөв, хариуцагч Зам, тээвэр хөгжлийн яам. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын Ж.Чинбүрэнгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол санал хураалт явуулъя. Саналын томъёолол 9, 3.3.2 эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх гэж байна. Саналын томъёолол. 3.3.2.3 гэсэн төсөл арга, хэмжээний дараа Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг гэж нэмэх. Улсын төсвөөс санхүүжих 25 тэрбум төгрөг, 100 хувь санхүүжих гэсэн байна. Санал хураалт. Зураг төсөл байгаа юм байгаа биз дээ? Газар нь байгаа. 90 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын зарчмын зөрүүтэй санал. Саналын томъёолол Баруун-Урт Сүхбаатар чиглэлийн 61,9км хатуу хучилттай авто зам, 24 юу гэж байгаа юм бэ зам? 24. 24 урт метр гүүр гэж байна. Сүхбаатар Баруун-Урт, Сүхбаатар сум, хугацаа 2024-өөс 26 он, улсын төсөв 68 тэрбум 999,83 мянган төгрөг болж байгаа юм байна. 830 мянган төгрөг болж байгаа юм байна. Ингээд 2024 онд гэсэн байна. Санхүүжилт нь 10 тэрбум төгрөг гэж байгаа юм байна шүү. Ганибал гишүүн. Санал хураалт. Санал хураалт санал 90 хувиар дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүний санал. Бодлогын үндэслэл төсөл, арга хэмжээ гэж байна. Авто тэнхлэгийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам шинээр барих, 32,4км. Ингээж байна шүү. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 8.1.9 гэж байгаа юм байна шүү. Тэгээд хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам

шинээр барих, 32,4км, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, гүйцэтгэх хувь гэсэн байна. Хувь заагаагүй байна. Зураг төсөв хийгдсэн. 2024 онд 29 тэрбум төгрөг гэж байна. Улсын төсөв хариуцагч Зам, тээвэр тээврийн хөгжлийн яам гэж байна шүү. Санал хураалт. Энэ баахан юмнуудыг ингээд арзайлгаад хаячихсан юм байна шүү дээ энэ чинь. Санал 40 хувиар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан саналын зөрүүтэй томъёолол. Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133,7км хатуу хучилттай авто замын үргэлжлэл 67,8км авто зам, төсөвт өртөг 87 тэрбум төгрөг, 87 тэрбум 354 сая 149 мянган төгрөг, санхүүжилтийн эх үүсвэр Улсын төсөв, 2020 онд санхүүжих дүн нь яах вэ хасчих юм уу 40 хувиар авчихъя. 40 хувь гэж байгаа юм. Санал хураалт. Одоо үргэлжилж байгаа зам наадах чинь ерөөсөө явж байгаа босоо тэнхлэгийн авто зам шүү. Ерөөсөө Зам тээвэр, Барилга, хот байгуулалтын яамны бодлогын хэмжээнд орчихсон бодлогын зам байж байгаа. Тийм. Тэр замын чинь үргэлжлэл байхгүй юу, одоо явж байгаа замын үргэлжлэл шүү. Санал 70 хувиар дэмжигдлээ. Энэ чинь яагаад, хэрүүл хийж байгаад аваачаад юу яасан байна. Санал 70 хувиар дэмжигдсэн.

Зарчмын зөрүүтэй санал Т.Энхтүвшин гишүүн. Энэ юун дээр та нар бөглөөд өгч байгаач. Тэгэхгүй тэгээд намайг шүүмжлүүлээд байх юм. Ингээд замбараагүй юмнууд өгөөд. Санал тогтоолын хавсралтын тэргүүлэх чиглэл 2 Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ гэсэн бүлэгт доорх агуулга бүхий 2.2.3.10 дахь заалтыг шинээр нэмэх. Саналын томъёоллын нөгөө хуудас байгаа шүү дээ. Уг нь энэ хуудсан дээр хэдүүлээ бөглөөд энэ Байнгын хорооныхон маань бөглөөд өгчхөж байгаарай, туслаад. 2.2.3.10 Төсөл, арга хэмжээний нэр Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Гэрэлт говь металлургийн коксын үйлдвэр үйлдвэрлэл технологийн парк байгуулах бодлогын үндэслэл ШСБ 3.14, ЗГҮАХ-ийн 3.2.7.1,

шалгуур үзүүлэлт барилгын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт 2022 он 35, 24 он 2024 он 35, санхүүжилт 375 тэрбум төгрөг, санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал дотоодын эх үүсвэр, хариуцагч УУХҮЯам. Хувийн эх үүсвэр гэсэн үг үү? Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин. Санал хураалт. Хувийн хөрөнгө оруулалтаар уу тийм ээ? Санал 90 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Батлут гишүүний гаргасан саналын зөрүүтэй томъёоллыг уншъя. Улаан, 2024 он Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийн саналын хавсралт, 2 дугаар хавсралтын 1.1.2 Авто замын сүлжээг өргөтгөх хэсгийн 1.1.2.7-д заасан дээр нэмэх. Саналын утга Улаанбаатар, Шар Хөтөл, Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 100км авто зам барих, санхүүжилт санхүүжилтийн дүн 150,34 тэрбум төгрөг, санхүүжилтийн эх үүсвэр гадаадын зээл тусламж, ЕСБХБ-ийн санхүүжилтээр гүйцэтгэнэ гэж байна. Саналын томъёоллоор тайлбар өгөх үү? Батлут гишүүн.

Д.Батлут: Энэ зам бол Улаанбаатар Дархан чиглэлийн авто замын 112 дахь километр орчмоос Дархан Эрдэнэтийн чиглэлийн улсын чанартай А1101 авто замын Орхон сумын уулзвар хүртэлх холбох авто замын зам юм байгаа юм. ТЭЗҮ-ийг нь боловсруулаад дууссан. Нийтдээ 92,23км авто зам, төсөвт өртөг нь 150,34 тэрбум төгрөг байгаа. Энэ замыг бол санхүүжүүлэх боломжтой гэдгийг Европын сэргээн босголтын банк илэрхийлсэн. Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нар бол дэмжиж байгаа. Санамж бичиг бол гарын үсэг зурчихсан байгаа юм. Энэ зам ашиглалтад орсноор бол хойд болон баруун чиглэлийн авто замын ачаалал 50 хувь буурах, тэр түүнээ дагаад бас осол зам тээврийн осол бол төдий хэмжээгээр буурах боломжтой.

Мөн дээрээс нь байгаль орчин хөдөө аж ахуйн салбарын хамгийн ойр дөт зам болох ийм боломжтой. Мөн энэ 5, 6 аймгийн 42 мянган өрхийн 150 орчим мянган иргэн бол ач тусыг нь үр ашгийг нь хүртэх боломжтой ийм авто зам гэж ойлгож байгаа. Энэ зам ашиглалтад орсноороо жилдээ бол нэг 25,7 сая ам.долларын ашиг хүртэх боломжийг иргэд болон ААН-д олгоно гэсэн ийм тооцоолол гаргасан байгаа юм. Тэгээд энэ саналыг та бүхэн дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Хурал өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт. Санал 70 хувиар дэмжигдлээ. Би дэмжиж байгаа шүү протоколд тэмдэглээрэй. Өөр нэг санал орж ирэх гэж байна, одоо нэг санал орж ирэх гэж байна. Би протокол дээр тэмдэглүүлчихсэн байгаа шүү, түүрүүн протоколд хэлчихсэн байгаа, тийм. Гялс өгөөдөх, үгүй ээ наашаа өгөөдөх л дөө. Одоо наадах чинь унана. Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналын томъёолол. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1.1 дэх заалтын санхүүжилтийн тэрбум 170 мянга гэснийг 3 тэрбум 500 гэж, зорилтот түвшинд 2000 гэснийг 1500 гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя.

Зарчмын зөрүүтэй саналаар, тогтоолын төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явагдаж дууслаа. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн сахилга, хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр уншиж танилцуулна.

12.56 цаг

